


VISA FINDER

БНСУ-д зорчих виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт



БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ

Агуулга Contents

1 Санамж	2
2 Виз мэдүүлэхтэй холбоотой түгээмэл асуултууд	3
3 Визний ангилал	4
4 Олон удаагийн виз болон хөнгөвчилсөн нөхцөл	
- Олон удаагийн виз	5
- Хөнгөвчилсөн нөхцөл	12
5 Визний зөвшөөрлийн код	17
6 Дипломат, Албан ажил (А-1, А-2)	18
7 Богино хугацааны айлчлал	
- Хэвлэл мэдээллийн ажил (С-1)	19
- Богино хугацааны урилга (С-3-1)	20
- Богино хугацааны аялал жуулчлал (С-3-9)	21
- Эмчилгээ (С-3-3)	22
- Богино хугацааны бизнес (С-3-4)	28
- Богино хугацааны хөдөлмөр эрхлэх (С-4-5)	29
8 Сургалтын виз	
- Их дээд сургуульд суралцах (D-2)	30
- Хэлний бэлтгэлд суралцах (D-4-1)	35
- Ерөнхий боловсролын сургуульд суралцах (D-4-3)	37
9 Хөрөнгө оруулалт, Гадаад худалдаа, Ажлын байр хайх	
- Хуулийн этгээдэд хөрөнгө оруулах (D-8-1)	38
- Гадаад худалдаа (D-9-4)	39
- Ажлын байр хайх (D-10)	40
10 Оршин суух	
- Оршин суух (F-1)	41
- Гэрлэлт цагаачлагчийн эцэг эх, гэр бүл (F-1-5)	43
- Урт хугацаагаар оршин суух (F-2)	45
- Дагалдан (F-3)	47
11 Гэрлэлт цагаачлал (F-6)	48
12 Хавсралт	
- Гадаад оюутан урих магадлан итгэмжлэгдсэн болон урихыг хязгаарласан сургуулийн жагсаалт	53
- ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлгийн жагсаалт	57
- E-9 Виз мэдүүлэгчийн эрүүл мэндийн асуумж	60
- ТОП 100 аж ахуйн нэгжийн жагсаалт	61
- Гэрлэлт цагаачлал (F-6) ангиллын визний шаардлагаас чөлөөлөгдөх хүсэлт	62
- Виз мэдүүлгийн төв (KVAC) болон албан ёсны төлөөлөн гүйцэтгэх байгууллагын жагсаалт	63



САНАМЖ



Виз мэдүүлэхийг хязгаарлах хугацааг мөрдөх(Ерөнхий нөхцөл)

- 1) Виз мэдүүлээд татгалзсан хариу авсан бол татгалзсан хариу олгосон өдрөөс **6 сарын дараа** виз мэдүүлнэ (2019.09.16-аас хэрэгжинэ.)
- 2) Гэрлэлт цагаачлал (F-6) ангиллын виз мэдүүлээд татгалзсан хариу авсан бол татгалзсан хариу өгсөн өдрөөс **6 сарын дараа** виз мэдүүлнэ

1. Виз мэдүүлэх гэж буй иргэн өөрийн биеэр **Солонгосын виз мэдүүлгийн төв(KVAC)** болон **албан ёсны төлөөлөн гүйцэтгэх байгууллагад** хандан өөрийн биеэр мэдүүлэх журамтай болно. Виз мэдүүлэх болон бүрдүүлэх бичиг баримтын талаар асууж лавлах зүйл байгаа тохиолдолд Солонгосын виз мэдүүлгийн төв болон албан ёсны төлөөлөн гүйцэтгэх байгууллагад хандаж мэдээлэл зөвлөгөө авна уу.
* Холбоо барих: KVAC 7766-8888, албан ёсны төлөөлөн гүйцэтгэх байгууллага(**хавсралт 6**)
2. Гадаад паспортын хүчинтэй хугацаа нь виз мэдүүлэг бүртгэгдсэн өдрөөс эхлэн тооцож **6 сар** ба түүнээс дээш хугацаа үлдсэн байх.
3. Бүх бичиг баримтыг **эх хувиар нь** мэдүүлэх ёстой бөгөөд, диплом, төрсний гэрчилгээ, гэрлэлт бүртгэлийн гэрчилгээ зэрэг бичиг баримтыг шалгаж дууссаны дараа эх хувийг буцаан олгох бөгөөд **бусад бичиг баримтыг буцаан олгохгүй**.
- Бүрдүүлж өгсөн бичиг баримтыг **хүчинтэй хугацаанд** нь багтааж өгөх ёстой ба хүчинтэй хугацааг тусгайлан заагаагүй бол зөвхөн олгогдсон өдрөөс хойш **3 сарын дотор** гаргасан бичиг баримтыг өгч болно.
4. МУ-ын төрийн байгууллагаас олгогдож буй лавлагаа(төрсний бүртгэлийн лавлагаа, гэрлэсний бүртгэлийн лавлагаа гэх мэт)-г **E-Mongolia**(ТҮЦ машин)-аас авсан байна. Хэрэв **E-Mongolia** (ТҮЦ машин)-аас авах боломжгүй, нэг цэгийн үйлчилгээний төвөөс авсан тохиолдолд төрсний гэрчилгээ, гэрлэлт бүртгэлийн гэрчилгээ зэргийг **эх хувиар** нь лавлагаатай нь хавсаргаж өгнө.
* **E-Mongolia-аас англи хэлээр олгогдож буй бичиг баримтыг орчуулах шаардлагагүй болно.**
5. Хуурамч, засварласан зэрэг зөрчилтэй бичиг баримт бүрдүүлж өгөх болон визний хууль бус үйлдэл гаргасан зөрчил нь **2 удаа илэрсэн тохиолдолд** уг этгээдийг Монгол улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх ба **БНСУ-ын хилээр нэвтрэхийг хязгаарлана.(2019.09.16-аас хэрэгжинэ)**
6. Виз мэдүүлгийн маягт дээр зорчих зорилго, холбогдох утасны дугаар, ажлын газар зэргийг хуурамчаар бичсэн тохиолдолд виз татгалзах шалтгаан болох бөгөөд **тодорхой хугацаагаар виз олгохоос татгалзана.**
7. Зорчих зорилгыг тодорхойлох зэрэг **визний мэдүүлгийг шалгахын** тулд шаардлагатай тохиолдолд бүрдүүлэх **бичиг баримтыг нэмж, хасах болон виз мэдүүлэгчидтэй ярилцлага** хийх боломжтой.
8. Виз олгогдсон боловч хилээр нэвтрэх нөхцөлийг хангахгүй гэж үзвэл БНСУ-ын нисэх онгоцны буудал, далайн боомт дээр **хилээр нэвтрүүлэхээс татгалзаж болно.**
9. **Урт хугацаагаар оршин суух** ангиллын виз мэдүүлэх эсвэл БНСУ-ын Хууль зүйн яамнаас тогтоосон оршин суух ангиллын виз мэдүүлэх тохиолдолд ЭСЯ-аас заасан эмнэлгээс сүрьеэгийн оношилгооны хуудас зайлшгүй бүрдүүлж өгнө.
(Дараах хүмүүст хамааралгүй: Дипломат/Албан ажлын виз мэдүүлэгч, 6-аас доош насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй)
- Сүрьеэгийн оношилгооны хуудас: Виз мэдүүлсэн өдрөөс **3 сарын** дотор авсан байх
10. **Давхар иргэншилтэй**(Монгол/Солонгос) **иргэдэд Монгол паспорт дээр нь БНСУ-д зорчих виз олгохгүй.** (БНСУ-ын паспорт байхгүй тохиолдолд ЭСЯ-нд хандан паспорт захиалж авна уу)
- Хэрэв, БНСУ-ын паспортаар зорчих боломжгүй хүндэтгэх шалтгаантай тохиолдолд энгийн (С-3) ангиллын виз мэдүүлэх боломжтой.
11. БНСУ-ын хилийн чанад дахь бүх дипломат байгууллагын ажилтан(захиргааны ажилтан) **шууд болон шууд бус байдлаар хүч хэрэглэх, зохисгүй үг хэлээр доромжлох зэрэг** визний материал шалгах үйл явцад хүндрэл учруулсан тохиолдолд доорх арга хэмжээг авна
 - 1) Зүй бус үг, хүчирхийлэл, дарамтлах, сүрдүүлэх зэрэг хүч хэрэглэсэн үйлдэл гаргасан тохиолдолд виз татгалзах болон виз мэдүүлэх эрхийг хязгаарлана. (1-3 жил хүртэл)
 - 2) Худал мэдүүлэг өгөх, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн тохиолдолд виз татгалзах болон виз мэдүүлэх эрхийг хязгаарлана. (6 сараас 3 жил хүртэлх)* **Уригч тал хүч хэрэглэх, зохисгүй үг хэлээр доромжлох зэрэг нь ч мөн адил виз мэдүүлэгчийн визний материал шалгах үйл явц болон үр дүнд нөлөөлж болно.**



Виз мэдүүлэхтэй холбоотой түгээмэл асуултууд

1 БНСУ-д визгүй зорчиж болох уу?

○ Аялал жуулчлал/дамжин өнгөрөх, төрөл садан дээрээ зочлох, бизнес, эмчилгээ, арга хэмжээнд оролцох зэрэг зорилгоор богино **хугацаагаар (90 хоног хүртэл)** БНСУ-д зорчих тохиолдолд дараах нөхцөлийг хангаж байгаа бол виз мэдүүлэх шаардлагагүй.

(Оршин суух зардлаас илүү хэмжээний цалин хөлс бүхий үйл ажиллагаа явуулах бол богино хугацаанд оршин суух байсан ч хөдөлмөр эрхлэх виз мэдүүлэх шаардлагатай)

- ▶ Монгол Улсын засгийн газраас олгосон хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэн ажил хэргийн шугамаар зорчих бол **(90 хоног хүртэл)**
- ▶ АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд болон Европын 32 орны хүчин төгөлдөр визтэй(хилээр дахин нэвтрэх зөвшөөрөл хамаарна) иргэн БНСУ-аар дамжин тухайн улс орнууд руу зорчих мөн тухайн улс орнуудад хууль ёсны дагуу оршин сууж байгаад БНСУ-ын шууд нислэгээр дамжин өнгөрч өөрийн улс болон 3-дагч улс руу зорчих тохиолдолд **(30 хоног хүртэл)**
 - ※ Австрали Улсын **Е-визтэй** иргэд тус улсын гадаадын иргэн харьяатын газрын визний мэдээлэл шалгах систем(VEVO, online.immi.gov.au)-д австралийн виз нь хүчинтэй эсэх нь шалгагдаж буй тохиолдолд хүлээн зөвшөөрнө
 - ※ Европын 32 орон: Австри, Бельги, Болгар, Герман, Грек, Дани, Ирланд, Исланд, Испани, Итали, Их Британи, Кипр, Латви, Литв, Лихтенштейн, Люксембург, Мальт, Нидерланд, Норвеги, Польш, Португали, Румын, Словак, Словени, Унгар, Финлянд, Франц, Хорват, Чех, Швед, Швейцар, Эстон

2 БНСУ-руу байнга зорчдог бол олон удаагийн виз мэдүүлж болох уу?

○ Жилд 3 ба түүнээс дээш аялал жуулчлал/дамжин өнгөрөх, төрөл садныдаа зочлох, бизнес, арга хэмжээнд оролцох зэрэг зорилгоор БНСУ-д зорчих шаардлага бүхий иргэн олон удаагийн визний нөхцөлийг хангаж байгаа бол олон удаагийн виз мэдүүлж болно.

▶ **ОЛОН УДААГИЙН ВИЗНИЙ НӨХЦӨЛ(ДЭЛГЭРЭНГҮЙ)**

3 Бүрдүүлэх бичиг баримт их, хөнгөвчилсөн байдлаар виз мэдүүлэх боломжтой юу?

○ Аялал жуулчлал/дамжин өнгөрөх, төрөл садан дээрээ зочлох, бизнес, эмчилгээ, арга хэмжээнд оролцох зэрэг зорилгоор БНСУ-д зорчих шаардлагатай иргэн хөнгөвчилсөн визний нөхцөлд хамрагдаж байгаа бол санхүүгийн чадвар нотлох бичиг баримт зэргийг бүрдүүлж өгөхөөс чөлөөлөгдөнө.

▶ **ХӨНГӨВЧИЛСӨН НӨХЦӨЛ(ДЭЛГЭРЭНГҮЙ)**

4 Визээ хэрхэн мэдүүлэх вэ?

○ Виз мэдүүлэхдээ БНСУ-ын виз мэдүүлгийн төв(KVAC) эсвэл албан ёсны төлөөлөн гүйцэтгэх байгууллагуудад хандах ба бүрдүүлэх бичиг баримт болон виз мэдүүлэхтэй холбоотой мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой.

▶ **СОЛОНГОСЫН ВИЗ МЭДҮҮЛГИЙН ТӨВ(KVAC) БОЛОН АЛБАН ЁСНЫ ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ(ДЭЛГЭРЭНГҮЙ)**

5 Визний хариу хэр удаж гарах вэ?

○ Визний хариу нь мэдүүлж буй ангиллаас шалтгаалж шалгах хугацаа нь харилцан адилгүй байдаг тул ЭСЯ-ны цахим хуудсанд дахь мэдээлэлтэй танилцана уу.

▶ **ЭСЯ-ны цахим хуудас(overseas.mofa.go.kr/mn-mn/index.do)**



ВИЗНИЙ АНГИЛАЛ

БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ нь энэхүү VISA FINDER танилцуулгыг виз мэдүүлэгч иргэн хялбар, хурдан шуурхай байдлаар өөрийн мэдүүлэх визний төрөл ба бүрдүүлэх бичиг баримтыг олж мэдэхэд туслах зорилгоор бэлтгэсэн болно.

VISA FINDER нь Монгол Улсын иргэдийн ихэвчлэн мэдүүлдэг визний төрөл ба бичиг баримтын талаарх мэдээллийг агуулах бөгөөд энд дурдагдаагүй визний төрөл ба бичиг баримтын талаарх мэдээллийг БНСУ-ын Шилжилт хөдөлгөөн, гадаад иргэний бодлого хариуцсан ерөнхий газрын цахим хуудас(www.immigration.go.kr) гадаад иргэдэд зориулсан цахим засаглал(www.hikorea.go.kr) сайтын визний танилцуулгаас(Мэдээлэл → Хилийн шилжилт хөдөлгөөн/Оршин суух → Виз/Урилга) лавлаж үзнэ үү. (정보마당 ⇒ 출입국/체류안내 ⇒ 사증/초청)

Богино хугацааны виз

Хүчинтэй хугацаа 3 сар, оршин суух хугацаа **90 хоног хүртэл**

Урт хугацааны виз

Хүчинтэй хугацаа 3 сар, оршин суух хугацаа **91 хоногоос дээш**



ДИПЛОМАТ/АЛБАН АЖИЛ

Дипломат/Албан ажил(A-1, A-2)



БОГИНО ХУГАЦААНЫ АЙЛЧЛАЛ

Хэвлэл мэдээллийн ажил (C-1)

Богино хугацааны бизнес (C-3-4)

Богино хугацааны урилга (C-3-1)

Богино хугацааны аялал жуулчлал (C-3-9)

Эмчилгээ(C-3-3)

Богино хугацааны хөдөлмөр эрхлэх (C-4-5)



СУРГАЛТ

Их дээд сургуульд суралцах (D-2)

Хэлний бэлтгэлд суралцах (D-4-1)

Ерөнхий боловсролын сургуульд суралцах (D-4-3)



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ/ГАДААД ХУДАЛДАА/АЖИЛ ХАЙХ

Хуулийн этгээдэд хөрөнгө оруулах (D-8-1)

Гадаад худалдаа (D-9-4)

Ажлын байр хайх (D-10)



ОРШИН СУУХ

Оршин суух (F-1)

Гэрлэлт цагаачлагчийн эцэг эх, гэр бүл (F-1-5)

Урт хугацаагаар оршин суух (F-2)

Дагалдан (F-3)



ГЭРЛЭЛТ ЦАГААЧЛАЛ

Гэрлэлт цагаачлал (F-6)



1. ОЛОН УДААГИЙН ВИЗ

1) Олгох хүрээ: Дараах 'А ~ Q' нөхцөлийг хангаж буй иргэн

- A. БНСУ-д зорчиж байсан иргэн
- B. Төрийн албан хаагч болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан(хэлтсийн даргаас дээш албан тушаалтан)
- C. БНСУ-руу тогтмол нислэг үйлддэг авиа компани, усан онгоцны компанийн үндсэн ажилтан(хэлтсийн даргаас дээш албан тушаалтан)
- D. \$10,000 доллароос дээш зээлийн эрхтэй олон улсад ашиглагддаг кредит карт эзэмшдэг, сүүлийн 3 сарын турш сарын дундаж хэрэглээ нь \$2,000 доллароос дээш зарцуулалттай карт эзэмшигч(бэлэн мөнгөний үйлчилгээ хамрагдахгүй)
- E. БНСУ-тай хамтран байгалийн баялаг, эрчим хүч олборлох, борлуулах зорилгоор аж ахуйн нэгж байгуулах, БНСУ-ын төрийн болон төрийн өмчит байгууллагын урилгаар хэлэлцээр хийх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагааны шугамаар зорчих иргэн
- F. БНСУ-ын иргэншилтэй болсон иргэний эцэг эх, хүүхэд, МУ-д оршин сууж байгаа БНСУ-ын иргэний эхнэр/нөхөр, мөн хоёр улсад гэрлэлтээ батлуулаад 1 ба түүнээс дээш жил хууль ёсны дагуу амьдарч буй БНСУ-ын иргэний эхнэр/нөхрийн эцэг эх, насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насны хүүхэд)
- G. Эмч, өмгөөлөгч, их сургуулийн багш зэрэг мэргэжлийн боловсон хүчин
- H. ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй сэтгүүлч, найруулагч, редактор зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж байгаа иргэн
- I. 1 жилийн турш төлсөн татварын хэмжээ нь 500 сая төгрөгөөс дээш байх эсвэл ТОП 100 аж ахуйн нэгжид хэлтсийн дарга болон түүнээс дээш албан тушаалд 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж буй иргэн
- J. БНСУ-д коллежоос дээш зэрэг хамгаалсан иргэн эсвэл бусад улсад магистраас дээш зэрэг хамгаалсан иргэн
- K. Сүүлийн 6 сарын турш нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт дээрх сарын үндсэн цалин нь нийслэлийн ажиллагсдын сарын дундаж цалин(2023 оны дундаж цалин 2.2 сая төгрөг)-гаас 2 дахин их, ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй иргэн
- L. ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй олны танил соёл урлагийн зүтгэлтэн, тамирчин (тухайн салбарт гавьяа зүтгэл гаргасан иргэн)
- M. 500 сая төгрөгөөс дээш үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн хөрөнгө(бэлэн мөнгө) зэрэг хувийн хөрөнгө эзэмшиж буй иргэн
- N. 'А~М, Q' нөхцөлийг хангаж олон удаагийн виз авсан иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насны хүүхэд)
- O. БНСУ-руу сүүлийн 2 жилийн дотор 4 ба түүнээс дээш, нийт 10-аас дээш(сүүлийн 2 жилд заавал нэг удаа зорчсон байх) зорчсон иргэн. (байнгын зорчигч)
- P. БНСУ-д эхнэр, нөхөр болон шууд хамаарал бүхий гэр бүл нь 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж буй иргэн
- Q. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(OECD)-ын гишүүн орны визтэй ба визээ ашиглан тухайн оронруу зорчсон иргэн

2) Олгох ангилал: Богино хугацаа (С-3-1), Богино хугацааны аялал жуулчлал (С-3-9)

3) Визний хүчинтэй хугацаа: 3 жил/5 жил

- 5 жилийн олон удаагийн виз: 3 жилийн хүчинтэй хугацаатай олон удаагийн виз авч, визний хугацаандаа 2 ба түүнээс дээш удаа зорчсон, оршин суух хугацаандаа аливаа зөрчил гаргаж байгаагүй иргэн, байнгын зорчигч
 - ※ Оршин суух хугацаандаа хууль бус хөдөлмөр эрхлэх(хилээр нэвтрээд 90 хоногийн турш оршин суусан зэрэг) болон хугацаа хэтрүүлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд виз олгох боломжгүй.

※ **3 ба 5 жилийн олон удаагийн визийг тухайн визний хүчинтэй хугацаагаар дуусахаас 1 сарын өмнө мэдүүлэх боломжтой.** (жишээ: 2025.01.31 өдөр визний хугацаа нь дуусах бол 2025.01.01 өдрөөс визээ мэдүүлэх боломжтой)

4) Оршин суух хугацаа(1 удаа): 90 хоног(дээрх 'O' нөхцөлд хамаарах байнгын зорчигч нь оршин суух хугацаа 30 хоногтой 5 жилийн олон удаагийн виз мэдүүлнэ)

А БНСУ-д зорчиж байсан иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт:
 - Санхүүгийн чадвар нотлох баримт эсвэл БНСУ-ын хилээр орж гарсныг нотлох баримт(виз олгосон тодорхойлолт болон хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар)
 4. Гэрлэлтийн лавлагаа
 5. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажиглагч: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ Олон удаагийн визийг тухайн визний хүчинтэй хугацаагаа дуусгавар болохоос өмнө дахин мэдүүлж буй тохиолдолд дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөнө.
- ※ Визгүй зорчдог ангилал тус нөхцөлд хамаарахгүй.
- ※ Эмчилгээний виз (С-3-3) ангиллын хувьд виз мэдүүлж буй өдрөөс өмнөх 1 жилийн дотор 2 сая воноос дээш мөнгөн дүнг цэвэр эмчилгээний зардалд зарцуулсан тохиолдолд олон удаагийн визний нөхцөлд хамааруулан тооцно. Бусад ангиллын визээр зорчсон тохиолдолд олон удаагийн визний нөхцөлд хамааруулан тооцно.

В Төрийн албан хаагч болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан(хэлтсийн даргаас дээш албан тушаалтан)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт :
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
4. Гэрлэлтийн лавлагаа

С БНСУ руу тогтмол нислэг үйлддэг авиа компани, усан онгоцны компанийн үндсэн ажилтан(хэлтсийн даргаас дээш албан тушаалтан)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт :
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт зэрэг
4. Гэрлэлтийн лавлагаа

Д \$10,000 доллараас дээш зээлийн эрхтэй олон улсад ашиглагддаг кредит карт эзэмшиж, сүүлийн 3 сарын турш сарын дундаж хэрэглээ нь \$2,000 доллараас дээш зарцуулалттай карт эзэмшигч(бэлэн мөнгөний үйлчилгээ хамрагдахгүй)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт :
 - Банкны тодорхойлолт(зээлийн кредит лимитийг бичүүлэх), картын хуулга
 - Картын хуулбар
4. Гэрлэлтийн лавлагаа

Е

БНСУ-тай хамтран байгалийн баялаг, эрчим хүч олборлох, борлуулах зорилгоор аж ахуй нэгж байгуулах, БНСУ-ын төрийн болон төрийн өмчит байгууллагын урилгаар хэлэлцээр хийх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагааны шугамаар зорчих иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5х4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт :
 - Байгалийн баялаг, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллага болохыг нотлох бичиг баримт (аж ахуй нэгжийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл гэх мэт)
 - Байгалийн баялаг, эрчим хүч олборлох, борлуулахтай холбоотойгоор БНСУ-ын талтай байгуулсан гэрээ
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
4. Гэрлэлтийн лавлагаа

Ф

БНСУ-ын иргэншилтэй болсон иргэний эцэг эх, хүүхэд, МУ-д оршин сууж буй БНСУ-ын иргэний эхнэр/нөхөр, мөн хоёр улсад гэрлэлтээ батлуулаад 1 ба түүнээс дээш хугацаагаар хууль ёсны дагуу амьдарч буй БНСУ-ын иргэний эхнэр/нөхрийн эцэг эх, насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насны хүүхэд)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5х4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэр бүл болохыг нотлох бичиг баримт
4. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Иргэншлээ солиулсан иргэн: Гадаад иргэнээр бүртгүүлсэн тухай тодорхойлолт(хилийн шалган нэвтрүүлэх албанаас олгох) эсвэл иргэний үндсэн мэдээллийн тодорхойлолт (дэлгэрэнгүй) өгөх
 - Монгол Улсад оршин сууж буй БНСУ-ын иргэн: Гадаад паспортын хуулбар, оршин суух үнэмлэхийн хуулбар
 - Хоёр улсад гэрлэлтээ батлуулаад 1 жил ба түүнээс дээш хугацаагаар хууль ёсны дагуу амьдарч буй иргэн: Солонгос, Монгол хоёр улсын гэрлэлтийн лавлагаа

Г

Эмч, өмгөөлөгч, их сургуулийн багш зэрэг мэргэжлийн боловсон хүчин

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5х4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - **Эмч:** Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ
 - **Өмгөөлөгч:** Ажлын газрын тодорхойлолт, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээ, Монголын Хуульчдын Холбоо гишүүний тодорхойлолт
 - **Их Сургуулийн Багш:** Ажлын газрын тодорхойлолт, ректорын тушаал(бакалавраас дээш сургалттай улсын болон хувийн их, дээд сургуульд ахлах багш болон түүнээс дээш албан тушаалд ажиллаж байгаа боловсон хүчин)
 - ✳ **Гэрээт багш, цагийн багш, зочин багш, зочин профессор зэрэг түр гэрээт багш нар хамрагдах боломжгүй**
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
5. Гэрлэлтийн лавлагаа

Н**ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй сэтгүүлч, найруулагч, редактор зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж байгаа иргэн****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын үнэмлэхийн хуулбар(сэтгүүлч, найруулагч, редактор зэрэг)
 - Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн тодорхойлолт, сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн гишүүний үнэмлэхийн хуулбар
 - Тухайн ажиллаж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагын татварын тодорхойлолт
 4. Гэрлэлтийн лавлагаа
- ✳ **ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй хэвлэл мэдээллийн ажилтан**
- Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн гишүүн бөгөөд хэвлэл мэдээллийн ажилтнаар 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж байгаа ажилтан

И**1 жилийн турш төлсөн татварын хэмжээ нь 500 сая төгрөгөөс дээш байх эсвэл ТОП 100 аж ахуйн нэгжид хэлтсийн дарга болон түүнээс дээш албан тушаалд 1 жилээс дээш хугацаагаар ажиллаж буй иргэн****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн цахим татварын тодорхойлолт(хамрах хугацаа: өмнөх оны 1 сарын 1-ээс 12 сарын 31-ний өдөр), Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
 4. Гэрлэлтийн лавлагаа
- ✳ **Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн жагсаалт(хавсралт 4)**

Ж**БНСУ-д коллежоос дээш зэрэг хамгаалсан иргэн эсвэл бусад улсад магистраас дээш зэрэг хамгаалсан иргэн****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Дипломын хуулбар, дүнгийн жагсаалт, бусад улсад оршин сууж байсан визний хуулбар, хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар эсвэл хил хамгаалах ерөнхий газрын улсын хил нэвтэрсэн тухай лавлагаа
 4. Гэрлэлтийн лавлагаа
- ✳ Монгол улсаас өөр улсад бакалавраас дээш зэрэг хамгаалсан тохиолдолд дипломын хуулбар дээрээ тухайн улсын ГХЯ-аас олгосон апостиль гэрчилгээ, эсвэл төгссөн сургуулийн **харьяа улсад суугаа БНСУ-ын ЭСЯ-аас консулын баталгаа хийлгэнэ.**
- ✳ БНХАУ-ын Боловсролын яамны харьяа боловсролын түвшин/зэрэг магадлан итгэмжлэх төвөөс олгосон боловсролын зэрэг хамгаалсан эсэх тодорхойлолт. **(БНХАУ-д төгсөгчдөд хамаарна)**

К

Сүүлийн 6 сарын турш нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт дээрх сарын үндсэн цалин нь нийслэлийн ажиллагсдын сарын дундаж цалин(2023 оны дундаж цалин 2.2 сая төгрөг)-гаас 2 дахин их, ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт(виз мэдүүлж буй өдрөөс өмнөх 12 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал)
4. Гэрлэлтийн лавлагаа

Л

ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй олны танил соёл урлагийн зүтгэлтэн, тамирчин(тухайн салбарт гавьяа зүтгэл гаргасан иргэн)

► ЭСЯ-ны холбогдох нөхцөлийг хангаж буй иргэн

- (Соёл урлагийн салбар) Төрийн дээд одон медалиар шагнуулсан иргэн(хөдөлмөрийн баатар, төрийн соёрхолт, ардын жүжигчин, гавьяат жүжигчин, урлагийн гавьяат зүтгэлтэн) зэрэг гавьяа зүтгэл гаргасан иргэн
- (Спортын салбар) Төрийн дээд одон медалиар шагнуулсан иргэн(хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, гавьяат дасгалжуулагч), Олимп болон Пара-олимпын медальт тамирчин, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний медальт тамирчин, Азийн спортын наадмын медальт тамирчин, өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн(төрөл бүрээр)-ийн медальт тамирчин зэрэг гавьяа зүтгэл гаргасан иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Одон медалийн хуулбар, үнэмлэхийн хуулбар
 - Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт(төлж буй тохиолдолд)
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
5. Гэрлэлтийн лавлагаа

М

500 сая төгрөгөөс дээш үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн хөрөнгө(бэлэн мөнгө) зэрэг хувийн хөрөнгө эзэмшиж буй иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэгдсэн хөрөнгийн үнэлгээний газрын тодорхойлолт(сүүлийн 6 сарын доторх)
 - Сүүлийн 6 сарын турш хадгалсан мөнгөн хадгаламжийн дүн: Дундаж үлдэгдлийн тодорхойлолт
4. Гэрлэлтийн лавлагаа

N**'A~M, Q' нөхцөлийг хангаж олон удаагийн виз авсан иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насны хүүхэд)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, Сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - Олон удаагийн виз эзэмшигч иргэний гэр бүл болохыг нотлох бичиг баримт
 - Олон удаагийн виз эзэмшигч болон түүний гэр бүлийн хүний дундаас гарсан хүүхдийн төрсний лавлагаа
 - Олон удаагийн виз эзэмшигч иргэний гадаад паспортын нүүр хэсэг, визтэй хэсгийн хуулбар

O**БНСУ-руу сүүлийн 2 жилийн дотор 4 ба түүнээс дээш, нийт 10-аас дээш(сүүлийн хоёр жилд заавал нэг удаа зорчсон байх) зорчсон иргэн(байнгын зорчигч)**

- Хүчинтэй хугацаа/1 удаа оршин суух хугацаа: 5 жилийн олон удаагийн виз/30 хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - БНСУ-ын хилээр орж гарсныг нотлох бичиг баримт(виз олгосон тодорхойлолт болон хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар)
4. Гэрлэлтийн лавлагаа
 - ✳ **Мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэх (E-9), далайчнаар ажиллах (E-10), улирлын чанартай хөдөлмөр эрхлэх(C-4, E-8) зэрэг энгийн хөдөлмөр эрхлэх ангилал, далайчин болон нэвтрэх зөвшөөрөл зэргээр БНСУ-ын хилээр нэвтэрсэн тохиолдолд БНСУ-д зорчсонд тооцохгүй**

P**БНСУ-д эхнэр, нөхөр болон шууд хамаарал бүхий гэр бүл нь(өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг, эх, хүүхэд) 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж буй иргэн****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - БНСУ-д оршин сууж буй гэр бүлийн иргэний гадаад иргэний үнэмлэхийн хуулбар(оршин суух хүчинтэй хаугацаа 6 сараас дээш үлдсэн байх)
 - Төрөл садангийн лавлагаа эсвэл төрсний бүртгэлийн лавлагаа
 - D-2~D-4 ангиллын визээр оршин сууж буй тохиолдолд сургуулийн тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт
 - E ангиллын визээр оршин сууж буй тохиолдолд ажлын газрын тодорхойлолт
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
5. Гэрлэлтийн лавлагаа



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(OECD)-ын гишүүн орны визтэй ба визээ ашиглан тухайн оронруу зорчсон иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт
 - OECD гишүүн орны виз болон хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн эх хувь
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
5. Гэрлэлтийн лавлагаа
 - * **Хүлээн зөвшөөрөгдөх OECD-ын 22 орон:** Австри, Бельги, Дани, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Шинэ Зеланд, Норвег, Португал, Испани, Швед, Швейцар, Их Британи, АНУ, Канад, Австрали, Финланд



2. ХӨНГӨВЧИЛСӨН НӨХЦӨЛ

1) Олгох хүрээ: Дараах 'А ~ J' нөхцөлийг хангаж буй иргэн

- A. Төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага зэргээс зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох урилгатай иргэн
- B. БНСУ-ын засгийн газрын зөвшөөрөл бүхий олон улсын байгууллагын урилгатай иргэн
- C. Албан, дипломат паспорт эзэмшигч албан ажлаас бусад зорилгоор энгийн паспортаа ашиглан зорчих
- D. Олон удаагийн визний нөхцөл хангасан болон олон удаагийн виз авч байсан иргэн
- E. Байнгын зорчигч(сүүлийн хоёр жилийн дотор 4 удаа, нийт 10-аас дээш удаа БНСУ-д зорчсон иргэн)
- F. БНСУ-руу сүүлийн 1 жилийн дотор богино хугацаагаар хоёроос дээш удаа зорчсон, худалдаа, бизнесийн холбоо хамаарал нь баримтаар нотлогдож буй иргэн
- G. БНСУ-ын иргэн(иргэншлээ солиулсан иргэн), болон БНСУ-ын иргэний эхнэр/нөхөр (F-6) ангиллын шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, хүүхэд)
- H. Урт хугацаагаар оршин суугч (F-2), Байнгын оршин суугч (F-5) ангиллын визтэй иргэний өөрийн болон эхнэр/нөхрийн шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, 19-өөс доош насны хүүхэд)
- I. Хэвлэл мэдээллийн ажил (D-5), Шашин (D-6), Суурин төлөөлөгч (D-7), Хөрөнгө оруулагч (D-8), Худалдаа эрхлэгч (D-9), E ангиллын виз (E-9 ангиллаас бусад) ангиллын визтэй иргэний шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, 19-өөс доош насны хүүхэд)
- J. 'C-F' нөхцөлийг хангасан иргэний гэр бүл(өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг эх, эмээ өвөө, 19-өөс доош насны иргэн)

2) Олгох ангилал: Богино хугацааны урилга (C-3-1), Богино хугацааны аялал жуулчлал (C-3-9)

3) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа):

- Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, Хоёр удаагийн дабль виз (D): 6 сар/90хоног

4) Анхаарах зүйлс: Дээрх нөхцөлийг хангаж буй боловч өмнө нь хууль зөрчиж байсан эсэх, хилээр зорчиж байсан, оршин сууж байсан тухай мэдээллүүдийг шалгаж үзнэ. Хууль бусаар оршин суух, хууль зөрчих магадлалтай гэж үзвэл виз олгохоос татгалзах бөгөөд зөвхөн бүрдүүлсэн бичиг баримтаар шалгах нь хангалтгүй гэж үзвэл нэмэлт бичиг баримтыг шаардаж болно.

A

Төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага зэргээс зохион байгуулж буй төрөл бүрийн арга хэмжээ, хурал семинар, богино хугацааны сургалт, нөхөрсөг тэмцээн уралдаанд оролцох урилгатай иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Хоёр улсын тухайн холбогдох байгууллагын албан хүсэлт
 - Монгол тал: Уригдагч байгууллагын танилцуулга, арга хэмжээний танилцуулга, зардал хариуцах тухай болон оролцогчдын нэрс, ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт(төлж буй тохиолдолд)
 - Солонгос тал: Арга хэмжээний танилцуулга, зардал хариуцах тухай(онгоцны билет, оршин суух зардал хэрхэн хариуцах гэх мэт), оролцогчдын нэрс, аж ахуй нэгжийн гэрчилгээ(бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбар: Уригч талын мэдээллийг оруулахад заавал шаардлагатай.
 4. Гэрлэлтийн лавлагаа
- * Урилга нь "invitation letter" гэсэн утгыг агуулах ба виз олгох зөвшөөрөл биш болно.**

В**БНСУ-ын засгийн газрын зөвшөөрөл бүхий олон улсын байгууллагын урилгатай иргэн****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Хоёр улсын тухайн холбогдох байгууллагын албан хүсэлт
 - Монгол тал: Байгууллагын танилцуулга, арга хэмжээний танилцуулга, зардал хариуцах тухай болон оролцогчдын нэрс
 - Солонгос тал: Арга хэмжээний танилцуулга, зардал хариуцагч тал(онгоцны билет, оршин суух зардал хэрхэн хариуцах гэх мэт), оролцогчдын нэрс, аж ахуй нэгжийн гэрчилгээ(бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбар зэрэг олон улсын байгууллага болохыг нотлох бичиг баримт: Уригч талын мэдээллийг оруулахад заавал шаардлагатай
4. Ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт зэрэг ажил байдлыг нотлох бичиг баримт
5. Гэрлэлтийн лавлагаа

С**Дипломат, албан паспорт эзэмшигч энгийн паспортаар аялал жуулчлал, эмчилгээ, төрөл садан дээрээ зорчих зэрэг албан ажлаас бусад зорилгоор зорчих****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт:
 - Хүчин төгөлдөр дипломат/албан паспортын хуулбар(хүчинтэй хугацаа хамгийн багадаа 3 сараас дээш байх), ажлын газрын тодорхойлолт
4. Гэрлэлтийн лавлагаа

Д**Олон удаагийн визний нөхцөл хангасан(А~М, Р, Q) болон олон удаагийн виз авч байсан иргэн(визний хүчинтэй хугацаа дуусгавар болсон өдрөөс 5 жил дотор)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт:
 - Визтэй хэсгүүд, хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар
4. Гэрлэлтийн лавлагаа

Е**Байнгын зорчигч(сүүлийн хоёр жилийн дотор 4 удаа, нийт 10-аас дээш удаа БНСУ-д зорчсон иргэн)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт:
 - Визтэй хэсгүүд, Хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар
 4. Гэрлэлтийн лавлагаа
- * Е-9, Е-10, С-4 ангиллын визээр зорчсон тохиолдолд хамаарахгүй**

F

БНСУ-руу сүүлийн 1 жилийн дотор богино хугацаагаар 2-оос дээш зорчсон, худалдаа, бизнесийн холбоо хамаарал нь баримтаар нотлогдож буй иргэн

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. БНСУ-ын аж ахуй нэгжтэй худалдаа хийсэн талаарх нотлох бичиг баримт
4. Хилийн шалган нэвтрүүлэх албаны тамга бүхий паспортын хуулбар
5. Гэрлэлтийн лавлагаа

G

БНСУ-ын иргэн(иргэншлээ солиулсан иргэн) болон БНСУ-ын иргэний эхнэр/нөхөр (F-6) ангиллын шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, хүүхэд)

- Виз мэдүүлэх хүрээ: Эхнэр/нөхөр, өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг эх, эмээ өвөө, 19-с доош насны хүүхэд
- Визний төрөл: С-3-1 (Богино хугацааны урилга)
- * БНСУ-ын иргэний эхнэр/нөхөр нь уригчтай хамт амьдрах зорилгоор виз мэдүүлэх тохиолдолд F-6 ангилалд хамаарна.**

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Төрсний бүртгэлийн лавлагаа(E-Mongolia-аас авсан байна)
4. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт(эхнэр/нөхрөө урьж буй тохиолдолд гэрлэлт бүртгэлийн лавлагаа)

УРИГЧ ТАЛ БҮРДҮҮЛЭХ

1. Урилга(эх хувь): Зайлшгүй эх хувиараа байх ба доорх агуулгыг багтаасан байна
 - Уригч болон уригдагчийн овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, иргэншил, регистрийн дугаар, утас
 - Уригч болон уригдагчийн холбоо хамаарал, урьж буй хугацаа, зорилго, батлан даалт зэрэг
 - БНСУ-ын иргэн: Уригч нь урилга дээр өөрийн хувийн тамгаа дарж(гарын үсэг зурж) тамгын гэрчилгээ (гарын үсгийн гэрчилгээ)-ний эх хувийг хавсаргах эсвэл нотариатаар баталгаажуулсан байна
 - Монгол Улсад оршин сууж буй БНСУ-ын иргэн : Эх орондоо буцаж ирэх тухай батлан даалтын бичиг (БНСУ-ын ЭСЯ-ны маягтыг ашиглах), Монгол улсад оршин суух үнэмлэхийн хуулбар, уригч нь урилга дээр өөрийн хувийн тамгыг дарж баталгаажуулна(хувийн тамгын гэрчилгээ шаардлагагүй)
- * Урилгын маягтыг БНСУ-ын ЭСЯ-ны цахим хуудаснаас татан авч хэрэглэх боломжтой бөгөөд ЭСЯ-ны маягтыг ашиглах боломжгүй тохиолдолд өөрийн маягтыг ашиглаж болно. (Тухайн маягт нь зайлшгүй ЭСЯ-ны маягт нь дээрх агуулгыг багтаасан байна.)**
2. Уригчийн биеийн байцаалтын хуулбар(иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, гадаад паспорт, гадаад иргэний оршин суух үнэмлэх)
3. БНСУ дахь гэрлэлтийн эсвэл ам бүлийн тодорхойлолт(сүүлийн 3 сарын дотор олгосон байх)
- * Монгол Улсын аливаа лавлагааг E-Mongolia-аас авсан байна. E-Mongolia-аас авах боломжгүй тохиолдолд тухайн гэрчилгээг эх хувиар нь өгнө**

Н**Урт хугацаагаар оршин суугч (F-2), Байнгын оршин суугч (F-5)-ийн өөрийн болон эхнэр/ нөхрийн шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, хүүхэд)**

- Виз мэдүүлэх хүрээ: Эхнэр/нөхөр, өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг эх, эмээ өвөө, 19-с доош насны хүүхэд
- Визний төрөл: С-3-1 (Богино хугацааны урилга)
- ※ **Урт хугацаагаар оршин суугч (F-2), байнгын оршин суугч иргэний (F-5) эхнэр/нөхөр, хүүхэд нь уригчтай хамт амьдрах зорилгоор виз мэдүүлэх тохиолдолд F-1/F-2 ангилалд хамаарна.**

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ БҮРДҮҮЛЭХ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Төрсний бүртгэлийн лавлагаа(E-Mongolia-аас авсан байна)
4. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт(эхнэр/нөхрөө урьж буй тохиолдолд гэрлэлт бүртгэлийн лавлагаа)

УРИГЧ ТАЛ БҮРДҮҮЛЭХ

1. Урилга(эх хувь): Зайлшгүй эх хувиараа байх ба доорх агуулгыг багтаасан байна
 - Уригч болон уригдагчийн овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, иргэншил, регистрийн дугаар, утас
 - Уригч болон уригдагчийн холбоо хамаарал, урьж буй хугацаа, зорилго, батлан даалт зэрэг
 - БНСУ-ын иргэн: Уригч нь урилга дээр өөрийн хувийн тамгаа дарж(гарын үсэг зурж) тамгын гэрчилгээ (гарын үсгийн гэрчилгээ)-ний эх хувийг хавсаргах эсвэл нотариатаар баталгаажуулсан байна
 - Монгол Улсын иргэн : Урилга болон БНСУ-ын иргэн эхнэр/нөхрийн урихыг зөвшөөрсөн бичиг(нотариат шаардлагатай)
- ※ **Урилгын маягтыг БНСУ-ын ЭСЯ-ны цахим хуудаснаас татан авч хэрэглэх боломжтой бөгөөд ЭСЯ-ны маягтыг ашиглах боломжгүй тохиолдолд өөрийн маягтыг ашиглаж болно. (Тухайн маягт нь зайлшгүй ЭСЯ-ны маягт нь дээрх агуулгыг багтаасан байна.)**
2. Уригчийн бичиг баримтын хуулбар(иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, гадаад паспорт, гадаад иргэний оршин суух үнэмлэх) болон эхнэр/нөхрийн биеийн байцаалтын хуулбар
3. БНСУ дахь гэрлэлтийн эсвэл ам бүлийн тодорхойлолт(сүүлийн 3 сарын дотор олгосон байх)

I**Хэвлэл мэдээллийн ажил (D-5), Шашин (D-6), Суурин төлөөлөгч (D-7), Хөрөнгө оруулагч (D-8), Худалдаа эрхлэгч (D-9), E ангиллын виз(E-9 ангиллаас бусад)-тэй иргэний шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, 19-өөс доош насны хүүхэд)**

- Виз мэдүүлэх хүрээ: Эхнэр/нөхөр, өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг эх, эмээ өвөө, 19-с доош насны хүүхэд
- Визний төрөл: С-3-1 (Богино хугацааны урилга)

ВИЗ МЭДҮҮЛЭГЧ БҮРДҮҮЛЭХ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа
4. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт

УРИГЧ ТАЛ БҮРДҮҮЛЭХ

1. Урилга(эх хувь) : Уригч нь урилга дээр өөрийн хувийн тамгаа дарж(гарын үсэг зурж) тамгын гэрчилгээ (гарын үсгийн гэрчилгээ)-ний эх хувийг хавсаргах эсвэл нотариатаар баталгаажуулсан байна
 - Уригч болон уригдагчийн овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, иргэншил, регистрийн дугаар, утас
 - Уригч болон уригдагчийн холбоо хамаарал, урьж буй хугацаа, зорилго, батлан даалт зэрэг
- ※ **Урилгын маягтыг БНСУ-ын ЭСЯ-ны цахим хуудаснаас татан авч хэрэглэх боломжтой бөгөөд ЭСЯ-ны маягтыг ашиглах боломжгүй тохиолдолд өөрийн маягтыг ашиглаж болно(Тухайн маягт нь зайлшгүй ЭСЯ-ны маягт нь дээрх агуулгыг багтаасан байна)**
2. Уригчийн гадаад иргэний оршин суух үнэмлэхийн хуулбар(хоёр тал), ажлын газрын тодорхойлолт
- ※ **Хөрөнгө оруулагч (D-8)-ийн хувьд аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, татварын тодорхойлолт зэрэг нэмэлт бичиг баримт өгөх**

J

'С~F' нөхцөлийг хангасан иргэний өөрийн болон эхнэр/нөхрийн шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх, эмээ өвөө, 19-өөс доош насны хүүхэд)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Гэрлэлтийн лавлагаа
 4. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт
 - Эхнэр/нөхрөө урьж буй тохиолдолд: Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
 - Өөрийн болон эхнэр/нөхрийн эцэг эх, хүүхдээ урьж буй тохиолдолд: Өөрийн болон эхнэр/нөхрийн, хүүхдийн төрсний бүртгэлийн гэрчилгээ(E-Mngolia-аас авсан байх)
- ※ E-Mongolia-аас авах боломжгүй тохиолдолд тухайн гэрчилгээг эх хувиар нь өгнө.



3. ВИЗНИЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОД

1) **Олгох хүрээ:** БНСУ-ын Хууль зүйн яамнаас визний зөвшөөрлийн код авсан иргэн

2) **Визний төрөл:** Визний зөвшөөрлийн кодтой визний журмын дагуу мэдүүлэх болон олгох

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/Хуулбар 1 хувь
3. Визний зөвшөөрлийн кодтой хуудас эсвэл зөвшөөрлийн код(урьж буй байгууллагын харьяа хилийн шалган нэвтрүүлэх газраас олгосон код)
4. Хилээр дахин нэвтрэх тодорхойлолт(холбогдох хүн)
5. Элсэлтийн зөвшөөрлийн хуулбар(D-2 ангиллын виз мэдүүлсэн тохиолдолд)



Ангилал тус бүрд нэмэлтээр бүрдүүлэх бичиг баримт

Бичиг баримтын төрөл	Тайлбар
Эрүүл мэндийн асуумж	Эрүүл мэндийн асуумж(хавсралт 3)
Эрүүл мэндийн хуудас	Эрүүл мэндийн шинжилгээний төрөл нь ДОХ/тэмбүү/сэтгэцийн өвчин/элэгний В вирусстэй эсэхийг эмнэлгийн тодорхойлолтод заавал тусгасан байна. Мөн тухайн аймаг орон нутгийн нэгдсэн эмнэлэг эсвэл түүнтэй дүйцэхүйц хэмжээний томоохон эмнэлгээс авсан тодорхойлолтыг хүлээн зөвшөөрнө.
Сүрьеэгийн шинжилгээний бичиг	ЭСЯ-наас заасан эмнэлгээс олгосон сүрьеэгийн шинжилгээний бичиг (хавсралт 2)
Цагдаагийн газрын тодорхойлолт	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаарх тодорхойлолт

※ БНСУ-ын хилээр гараад 6 сарын дотор дахин E-8 ангиллын виз мэдүүлэх гэж буй шилдэг ажилтны хувьд дээрх **эрүүл мэндийн хуудас, сүрьеэгийн шинжилгээний бичиг, цагдаагийн газрын тодорхойлолтоос чөлөөлөгдөнө**

Бичиг баримтын төрөл	E-9	E-8	C-4	F-3/F-1-15	Бусад	
					90 хоног хүртлэх	90 хоногоос дээш
Эрүүл мэндийн асуумж	○					
Эрүүл мэндийн хуудас	○	○	○			
Сүрьеэгийн шинжилгээний бичиг	○	○	○	○		○
Цагдаагийн газрын тодорхойлолт	○	○				



4. ДИПЛОМАТ/АЛБАН АЖИЛ (А-1, А-2)

1 Дипломат (А-1)

1) Олгох хүрээ:

- Дипломат паспорт эзэмшигч гадаад улсын засгийн газрын дипломат төлөөлөгч, консулын газар хэлтсийн ажилтан, мөн олон улсын журмын дагуу дипломат албатай дүйцэхүйц тусгай эрх бүхий иргэн болон түүний гэр бүл
- Энгийн паспорт эзэмшигчийн хувьд зөвхөн дипломат албан үүрэг гүйцэтгэгч болон түүний гэр бүлд олгох боломжтой

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, 91 хоногоос дээш, Олон удаагийн виз (M): 1 жил/90хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
4. ГХЯ-ны сайдын албан бичиг, олон улсын байгууллага бол байгууллагын даргын албан хүсэлт
 - Дипломат паспорт эзэмшигч иргэн 90 хоног хүртэл дипломат ажлын шугамаар зорчих бол визгүй зорчих бөгөөд БНСУ-д томилогдон оршин суух бол хоёр улсын хэлэлцээрийн дагуу шийдвэрлэх
5. Ажлын газрын тодорхойлолт эсвэл хөдөлмөрийн гэрээний хуулбар зэрэг ажил эрхэлж буйг батлах бичиг баримт
6. Урт болон богино хугацаагаар томилогдон ажиллах бол томилолтын тушаал зэрэг дипломат албан ажил гүйцэтгэж буйг батлах бичиг баримт
7. Хамт зорчих гэр бүл бол түүнийг нотлох бичиг баримт

2 Албан ажил (А-2)

1) Олгох хүрээ:

- Албан паспорт эзэмшигч гадаад улсын засгийн газар болон олон улсын байгууллагын албан ажил эрхлэх зорилгоор зорчих мөн хамт зорчих түүний гэр бүл
- Энгийн паспорт эзэмшигч нь албан үүрэг гүйцэтгэгч болон олон улсын байгууллагын ажилтан мөн түүний гэр бүлд олгох боломжтой
- Зорчих зорилго болон ажлын газраар: А-2-1 (Гадаад улсын засгийн газар), А-2-2 (Олон улсын байгууллага), А-2-3 (Нэгдсэн Үндэсний Байгууллага), А-2-4 (Бусад албан ажил)

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, 91 хоногоос дээш, Олон удаагийн виз (M): 1 жил/90хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
4. ГХЯ-ны сайдын албан бичиг эсвэл харьяа яамны сайдын албан бичиг, Олон улсын байгууллага бол байгууллагын даргын албан хүсэлт
 - Албан паспорт эзэмшигч иргэн 90 хоног хүртэл албан ажлын шугамаар зорчих бол визгүй зорчих бөгөөд БНСУ-д томилогдон оршин суух бол хоёр улсын хэлэлцээрийн дагуу шийдвэрлэх
5. Ажлын газрын тодорхойлолт эсвэл хөдөлмөрийн гэрээний хуулбар зэрэг ажил эрхэлж буйг батлах бичиг баримт(албан үүрэг гүйцэтгэж буйг бичиг тэмдэглэх)
6. Урт болон богино хугацаагаар томилогдон ажиллах бол томилолтын тушаал зэрэг албан ажил гүйцэтгэж буйг батлах бичиг баримт
7. Хамт зорчих гэр бүл бол түүнийг нотлох бичиг баримт



5. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛ (С-1)

1) Олгох хүрээ:

- Монголын сонин хэвлэл, телевиз радио, сэтгүүл бусад хэвлэл мэдээллийн байгууллагаас томилогдон богино хугацааны сурвалжлаг хийх, мэдээлэл дамжуулах иргэн
- Гадаадын мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээн дагуу богино хугацаагаар томилогдон сурвалжлаг хийх, мэдээлэл дамжуулах иргэн
- Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын охин компанийг байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор богино хугацаагаар ажиллах иргэн

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
4. Томилолтын бичиг
5. Ажлын газрын тодорхойлолт болон сурвалжлагчийн үнэмлэх(гадаад мэдээ дамжуулах сурвалжлагчийн үнэмлэх)
6. Байгууллагын аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар



6. БОГИНО ХУГАЦААНЫ УРИЛГА (С-3-1)

1) Олгох хүрээ:

- БНСУ-д зохион байгуулагдаж буй нөхөрсөг тэмцээн уралдаан, үйл ажиллагаа, хурал цуглаан зэрэгт оролцох, улс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас зохион байгуулагдаж буй техник, технологийн дадлага сургалтад хамрагдахын тулд богино хугацаагаар зорчих иргэн
- Богино хугацааны урилга (С-3-1), Богино хугацааны бизнес (С-3-4) ангилал нь виз мэдүүлэгчийн мэдүүлгийн маягт дээр бичсэн зорчих зорилго болон бүрдүүлсэн бичиг баримтыг үндэслэн шийдвэрлэгдэнэ.
- ※ **Дээрх богино хугацааны урилга (С-3-1) ангилалд хамаарагдах хэдий ч амьжиргааны зардлаас илүү хэмжээний төлбөр авах тохиолдолд, богино хугацааны хөдөлмөр эрхлэх (С-4-5) ангиллын виз мэдүүлнэ.**
- ※ **Урилга нь "invitation letter" гэсэн утгыг агуулах ба виз олгох зөвшөөрөл биш болно.**

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа (Эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дансны хуулгыг хураангуй хэлбэрээр өгөх**
- ※ **19-өөс доош насныхан болон 55-аас дээш насныхан гэр бүлийн хамт виз мэдүүлэх тохиолдолд санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөнө.**
5. Урилгатай холбоотой бичиг баримт(※ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбараас бусад урилгатай холбоотой бичиг баримтуудыг эх хувиар өгөх ба нотариат шаардлагагүй)
 - **Солонгос талын уригч байгууллага**
 - Урилга(уригдагчийн овог нэр, урьж буй зорилго, зардал хариуцагч, урих хугацаа зэргийг заавал бичнэ)
 - ※ **Уригч байгууллага нь өөрсдийн ашигладаг загвар байхгүй тохиолдолд уриалгын загварыг БНСУ-ын элчин сайдын яамны цахим хуудаснаас татаж авах боломжтой.**
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Албан хүсэлт(урилга болон албан хүсэлтийг хамтатган бичих боломжтой зэргийг заавал бичнэ)
 - Үйл ажиллагаа(сургалт, дадлага, семинар, албан уулзалт зэрэг)-ны хөтөлбөр, үйл ажиллагааны танилцуулга, зорчих зорилгыг нотолсон бичиг баримт
 - **Монгол талын уригч байгууллага**
 - (Багаар уригдах тохиолдолд) Байгууллагын албан хүсэлт
 - (Хувь хүн) Хувь хүний хүсэлт
 - **БНСУ-ын Спортын хорооны урилга**
 - БНСУ-ын Спортын Хороо болон харьяа байгууллагын урилга, мөн холбогдох төрийн яам агентлагийн сайдын албан хүсэлттэй тохиолдолд санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөх боломжтой.
 - ※ **БНСУ-ын Спортын хорооны харьяа байгууллагын бүртгэлээс шалгах шаардлагатай(www.sports.or.kr)**



7. БОГИНО ХУГАЦААНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ (С-3-9)

- 1) Олгох хүрээ:** 90 хоног хүртэл хугацаагаар БНСУ-д аялах, БНСУ-аас нисэх онгоц, усан онгоцонд дамжин суух зорилгоор тус улсын хилээр нэвтрэх тохиолдолд
- 2) Визний төрөл**(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, Хоёр удаагийн дабль виз (D): 6 сар/90хоног, Олон удаагийн виз (M): 3 жил, 5 жил/90 хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дансны хуулгыг хураангуй хэлбэрээр өгөх**
- ※ **Зөвхөн БНСУ-д хөдөлмөрийн гэрээ (Е-9-1) ангиллаар ажиллаж буй иргэний шууд хамаарал бүхий гэр бүлийн гишүүн нь сүүлийн 6 сарын шилжүүлэг хийсэн бичиг баримт болон дансны хуулга(банкны гүйлгээний баримт эх хувь), гадаад иргэний үнэмлэхийн хуулбар(урд тал, ард тал)**
4. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
- ※ **19-өөс доош насныхан болон 55-аас дээш насныхан гэр бүлийн хамт виз мэдүүлэх тохиолдолд санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөнө.**

НАС БАРСАН ИРГЭНИЙ АР ГЭР

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
4. Нас барсан талаарх эмнэлгийн тодорхойлолт
5. Монгол Улсын ГХЯ-ны нот бичиг
6. Гэрлэлтийн лавлагаа, төрөл садангийн тухай лавлагаа



8. ЭМЧИЛГЭЭ (С-3-3)

1) Олгох хүрээ: Өвчтөн болон хамт зорчиж буй гэр бүл

- **Хамт зорчих гэр бүл:** Өвчтөний шууд хамаарал бүхий гэр бүл(эмээ өвөө, эцэг эх, хүүхэд, ач зээ) болон эхнэр/нөхөр

- Эхнэр/нөхөр болон өвчтөний шууд хамаарал бүхий гэр бүл байхгүй эсвэл өвчтөний асран хамгаалагч солигдох шаардлагатай тохиолдолд төрсөн ах(эгч), дүүг хамт зорчих асран хамгаалах гэр бүлээр хүлээн зөвшөөрнө

※ Өвчтөний асрагч(гэр бүлээс бусад) хувьд зөвхөн гадаад улс руу өвчтөн илгээх гэрээтэй орны **улсын зардлаар өвчтөнийг асарч байгаа тохиолдолд хамаарна.** (МУ нь өвчтөн илгээх гэрээт улс биш болно)

2) ЭСЯ-наас заасан Монгол эмнэлэг: Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын 1, 2, 3-р төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Интермед эмнэлэг, Грандмед эмнэлэг, УБ Сонгдо эмнэлэг

※ **Монгол эмнэлгийн тодорхойлолтын агуулга солонгос эмнэлгийн урилга дээр заасан эмчилгээний зорилготой нийцэж байх.**



Өвчтөнтэй хамт зорчих гэр бүл болон асран хамгаалагч нь өвчтөнтэй хамт БНСУ-ын хилээр нэвтрэхгүй тохиолдолд эмчилгээний (С-3-3) ангилалд хамаарахгүй.

НИЙТЛЭГ БИЧИГ БАРИМТ

1. Эмнэлгийн урилга(эх хувь, хуулбар байх боломжгүй)
2. Цаг захиалгын бичиг
3. Тухайн эмнэлгийн аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
4. Гадаад өвчтөн хүлээж авах эрх бүхий байгууллагын гэрчилгээ

1**БНСУ-д өмнө нь эмчилгээний (С-3-3) визээр 2 ба түүнээс дээш удаа зорчсон иргэн (зөвхөн өвчтөнд хамаарна)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. Нөхцөл хангаж буйг нотлох бичиг баримт: Гадаад паспортын визтэй хэсгүүд болон хилийн шалган нэвтрүүлэх албаны тамгатай хэсгүүдийн хуулбар(журмын шинэчлэлийн дагуу виз болон хилийн шалган нэвтрүүлэх ажилтны тамга дарахгүй болсон зэргийг харгалзан үзэн өргөдлөөр авах боломжтой)

8. Гэрлэлтийн лавлагаа

9. Өмнө зорчихдоо эмчилгээ хийлгэсэн тухай нотлох бичиг баримт(эмнэлгийн онош, хугацаа болон эмчилгээ хийлгэсэн мэдээлэл хоорондоо уялдаа холбоотой байх)

10. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт

- Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

- Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт

- Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)

*** Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх****2****Үзлэг(мэс засал)-н төлбөрт 10 сая вон ба түүнээс дээш хэмжээний төлбөр урьдчилан төлсөн иргэн(зөвхөн өвчтөнд хамаарна)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. Урьдчилан төлсөн төлбөрийн баримт :

- Солонгос талын эмнэлгийн төлбөр урьдчилан авсан тодорхойлолт, төлбөр шилжүүлсэн баримт, дансны хуулга, карт болон бэлэн мөнгөний орлогын баримт гэх мэт(төлбөр төлөгч, хүлээн авагчийн нэр бичигдсэн байх)

*** Шууд хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийн нэрээр шилжүүлсэн байж болно**

8. ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн онош

9. Гэрлэлтийн лавлагаа

10. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт

- Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

- Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт

- Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)

*** Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх****3****БНСУ-д мэс засал хийлгэх иргэн(зөвхөн өвчтөнд хамаарна)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. ЭСЯ-аас заасан Монгол эмнэлгийн онош болон БНСУ-ын эмнэлгийн мэс засал хийлгэх цаг захиалгын бичиг

8. Гэрлэлтийн лавлагаа

9. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт

- Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

- Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт

- Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)

*** Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**

4 Яаралтай, хүнд өвчтөн(зөвхөн өвчтөнд хамаарна)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**
 5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 7. Гэрлэлтийн лавлагаа
 8. ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн онош
 9. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**

5 Өндөр насны тэтгэвэрт гарсан иргэн(зөвхөн өвчтөнд хамаарна)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**
 5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 7. Тэтгэврийн дэвтрийн хуулбар
 8. ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн онош
 9. Гэрлэлтийн лавлагаа
 10. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга (хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**

6 Сүүлийн 2 жилийн дотор 1-ээс дээш удаа БНСУ-д мэс засал хийлгэж байсан иргэн (зөвхөн өвчтөнд хамаарна)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**
 5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 7. Өмнө нь үзүүлж байсан эмнэлгийн бичиг болон цаг захиалгын бичиг (эмнэлгийн онош, давтан үзлэг хийлгэх, эмнэлгийн хяналтад тогтмол орох шаардлагатай талаар дурдсан байна)
 8. Гэрлэлтийн лавлагаа
 9. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**

7**БНСУ-ын сайн дурын байгууллагын тусламжтай үнэ төлбөргүй мэс засал хийлгэх иргэн(зөвхөн өвчтөнд хамаарна)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. Гэрлэлтийн лавлагаа

8. ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн онош

9. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт

- Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар

- Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт

- Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)

*** Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**

8**Өвчтөнтэй хамт зорчиж буй гэр бүл****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. Гэрлэлтийн лавлагаа, төрөл садангийн лавлагаа



Эмчилгээ (олон удаагийн С-3-3)

1) Олгогдох хүрээ: Өвчтөн болон түүний гэр бүл

- Эмчилгээ хийлгэж олон удаа зорчих зайлшгүй шаардлагатай өвчтөн
- Хамт зорчих гэр бүл: Өвчтөн 19 наснаас доош тохиолдолд шууд хамаарал бүхий гэр бүл(эцэг эх)
 - Анх удаагаа олон удаагийн виз мэдүүлж байгаа тохиолдолд "Виз мэдүүлэхэд бүрдүүлэх материалын журам"-д заасан олон удаагийн виз мэдүүлэх нөхцөлийг хангаж байгаагаа баталсан тохиолдолд олгох боломжтой.
 - Олон удаагийн эмчилгээний визээр зорчиж байсан тохиолдолд эмчлүүлсэн эмчилгээний түүхийг нотлох бичиг баримтаар хавсаргаж өгнө.
 - ※ Хууль бусаар ажил хөдөлмөр эрхэлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд виз олгох боломжгүй.

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): **3 сар/90 хоног**, 3 жил/5 жил

- 5 жилийн олон удаагийн виз: 3 жилийн олон удаагийн виз авч тухайн хугацаанд аливаа зөрчил гаргаж байгаагүй иргэн

※ **3 ба 5 жилийн олон удаагийн визийг тухайн визний хүчинтэй хугацаагаас дуусахаас 1 сарын өмнө мэдүүлэх боломжтой.** (Жишээ нь: 2024.01.31 өдөр визний хугацаа нь дуусах бол 2024.01.01 өдрөөс визээ мэдүүлэх боломжтой)

1

Олон удаа зорчих шаардлагатай өвчтөн(зөвхөн өвчтөнд хамаарна)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1-4. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх **нийтлэг бичиг баримт**

5. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

6. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

7. Гэрлэлтийн лавлагаа

8. Солонгос эмнэлгийн урилга

- Урилга дээр олон удаа зорчих шаардлагатай гэсэн агуулга багтсан байна

9. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт

- Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
- Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)

※ **Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх**



ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн жагсаалт

1 Гэмтэл согог судлалын үндэсний төв

Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж
Утас	+976) 7018-0136
Веб хуудас	www.gemtel.mn

2 Хавдар судлалын үндэсний төв

Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Намъяанжугийн гудамж
Утас	+976) 72724000, 70150437
Веб хуудас	www.cancer-center.gov.mn

3 Улсын 1-р төв эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, С.Зоригийн гудамж 2
Утас	+976) 7711-1027
Веб хуудас	www.unte.moh.gov.mn

4 Улсын 2-р төв эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө
Утас	+976) 7015-0222, 7015-0234, 7015-0255
Веб хуудас	www.ssch.gov.mn

5 Улсын 3-р төв эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө
Утас	+976) 7704-6666, 7700-0351
Веб хуудас	www.shastinhospital.mn

6 Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 11-р хороо, Хувьсгалчдын гудамж
Утас	+976) (11) 362205
Веб хуудас	www.ehemut.mn

7 Интермед эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө
Утас	+976) 7701-1111
Веб хуудас	www.intermed.mn

8 Грандмед эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан
Утас	+976) 7700-0066
Веб хуудас	www.grandmed.mn

9 УБ Сонгдо эмнэлэг

Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Д.Чойдогийн гудамж 5
Утас	+976) 7575-2727, 7011-1163
Веб хуудас	www.songdo.mn



9. БОГИНО ХУГАЦААНЫ БИЗНЕС (С-3-4)

- 1) Олгох хүрээ:** Зах зээлийн судалгаа, ажил хэргийн холбоо тогтоох, зөвлөгөө, гэрээ байгуулах, бага хэмжээний гадаад худалдаа зэрэг үүнтэй адил зорилгоор богино хугацаагаар зорчих иргэн
- 2) Визний төрөл**(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, Хоёр удаагийн дабль виз (D): 6 сар/90хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
 3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
 - ※ **Дансны хуулгыг хураангуй хэлбэрээр өгөх**
 4. Урилга(уригдагчийн овог нэр, урьж буй зорилго, зардал хариуцагч, урих хугацаа зэргийг заавал бичнэ), аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - ※ **Уригч байгууллага нь өөрсдийн ашигладаг загвар байхгүй тохиолдолд уриалгын загварыг БНСУ-ын элчин сайдын яамны цахим хуудаснаас татаж авах боломжтой.**
 5. Бизнесийн зорилгыг нотлох бичиг баримт
 - Худалдан авах гэрээ, үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө, В/L, экспорт/импортын лиценз, татварын баримт, валют солиулсан бичиг гэх мэт
 6. Гэрлэлтийн лавлагаа
-



10. БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ (С-4-5)

1) Олгох хүрээ: Түр хугацааны үзүүлбэр(урлагийн үйл ажиллагаа гэх мэт), зар сурталчилгаа/загвар өмсөх, лекц/илтгэл тавих*, судалгаа шинжилгээ хийх, технологи зааж сургах, ажил үйлчилгээ нийлүүлэх зэрэг ашгийн зорилгоор богино хугацааны хөдөлмөр эрхлэх иргэн

* Ашиг олох гэрээний дагуу БНСУ-ын төрийн болон хувийн байгууллагаас уригдаж богино хугацаагаар лекц, илтгэл тавих тохиолдолд

- ▶ Үзэсгэлэнд оролцох зураач, уран барималч гэх мэт уран бүтээл худалдах зэргээр ашиг олох тохиолдолд
- ▶ Улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт **богино хугацааны (С-4-1~4) ангиллын визний хувьд "Визний зөвшөөрлийн код"** мэдүүлэх шаардлагатай
- ※ **Хөдөлмөр эрхлэх хугацаа 91 хоногоос дээш тохиолдолд урлаг соёлын арга хэмжээ(Е-6) ангилалд хамаарагдах бөгөөд "Визний зөвшөөрлийн код" мэдүүлэх шаардлагатай**

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног, Хоёр удаагийн дабль виз (D): 6 сар/90хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Татварын тодорхойлолт, аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад: Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй)
- ※ **Дансны хуулгыг хураангуй хэлбэрээр өгөх**
4. Гэрлэлтийн лавлагаа
5. Урилга(урих болсон шалтгаан, эх орондоо буцаж ирэхийг батлан дааж буй агуулгыг тусгах)
6. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, Хуулийн этгээдийн гэрчилгээний лавлагаа гэх мэт
- ※ **Англи хэлний зуслан зэрэг гадаад хэл, яриа зааж сургах тохиолдолд Насан туршийн боловсролын байгууллагын бүртгэл гэх мэт бүртгэл зөвшөөрөгдсөн талаарх бичиг баримт**
7. Хөдөлмөрийн гэрээ болон зохион байгуулагч талаас арга хэмжээнд оролцохыг тодорхойлсон бичиг баримт
8. Холбогдох засаг захиргааны байгууллагын даргын ажилд авахыг санал болгосон тодорхойлолт эсвэл албан бичиг, ажилд авах зайлшгүй шаардлагыг нотлох бичиг баримт
 - Уран бүтээлчийн хувьд БНСУ-ын медиа контент үнэлгээний хорооны санал болгосон тодорхойлолт
 - Мэргэжлийн хөл бөмбөг буюу тамирчин, ахлагч, шүүгчийн хувьд БНСУ-ын хөл бөмбөгийн хорооны санал болгосон тодорхойлолт
 - Мэргэжлийн Го даамны тамирчны хувьд БНСУ-ын Го даамны холбооны санал болгосон тодорхойлолт
 - Дэвшилтэт технологи эзэмшсэн буюу(Gold болон IT карт) эзэмших нөхцөл хангасан мэргэжлийн боловсон хүчний хувьд БНСУ-ын аж үйлдвэр, технологийн сан болон БНСУ-ын IT Venture компани, жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооны санал болгосон тодорхойлолт
 - Гадаадын мэргэжлийн боловсон хүчний хувьд жижиг дунд бизнесийн корпорацаас санал болгосон тодорхойлолтыг ажил байдлыг нотлох бичиг баримтын оронд бүрдүүлж өгөх боломжтой
- ※ **БНСУ-д зорчих зорилгын дагуу нэмэлт бичиг баримт шаардах боломжтой**



11. ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАХ (D-2)

1) Олгох хүрээ: Коллеж ба түүнээс дээд шатны боловсролын байгууллага эсвэл эрдэм шинжилгээ болон судалгааны байгууллагад суралцах, судалгаа хийх гэж буй иргэн

► **GKS засгийн газрын тэтгэлэгт оюутан:** Визний хураамжаас чөлөөлөгдөнө

► Гадаад оюутан элсүүлэх болон хянах эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн сургуулийн жагсаалтыг **хавсралт 1**-ээс харна уу(www.studyinkorea.go.kr)

2) Визний төрөл: 2 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

3) Товчлол болон тайлбар

Товчлол	Нэршил	Тайлбар
D-2-1	Коллежид суралцах	
D-2-2	Бакалаврын түвшинд суралцах	
D-2-3	Магистрын түвшинд суралцах	
D-2-4	Докторын түвшинд суралцах	
D-2-5	Судалгаа хийх	
D-2-6	Солилцооны оюутан	
D-2-7	Ажил/сургалт хавсарсан	
D-2-8	Богино хугацаагаар суралцах	

4) Нэршил тус бүр дээрх виз олгох эсэх хүснэгт:

Төрөл	Визний ангилал	Виз олгох	Кодтой виз олгох	Цахим виз
Шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургууль	D-2-1~8	О	О	О
Магадлан итгэмжлэгдсэн сургууль	D-2-1~2,5,6,7,8	О	Х	Х
	D-2-3, D-2-4	О	Х	О
Энгийн их дээд сургууль	D-2-1~8	О	Х	Х
Зэрэглэл доогуур их дээд сургууль	D-2-1~5,7	О	Х	Х
	D-2-6, D-2-8	Х	О	Х

1 Коллеж болон түүнээс дээш түвшинд суралцах (D-2-1 ~ D-2-4)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
- Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
- Товч намтар(ЭСЯ-ны маягтын дагуу бөглөх, MS Word, Hangul программ ашиглах, заавал өөрийн гараар гарын үсгээ зурах), (GKS тэтгэлэгт оюутан болон БНСУ-ын их дээд сургуулийн бүрэн тэтгэлэгт оюутан, шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд хамаарахгүй)
- Элсэлтийн зөвшөөрөл болон сургуулийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - ※ **GKS тэтгэлэгт оюутны хувьд сургалтын албаны даргын урилга, жилийн чөлөө аваад сургуульдаа дахин элсэж байгаа оюутны хувьд дүнгийн тодорхойлолт болон сургуулийн тодорхойлолт эх хувиар авах шаардлагатай.**
- Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт болон дансны хуулга(GKS тэтгэлэгт оюутан, шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд хамаарахгүй)
 - **Дансны хуулга:** Өөрийн, эсвэл эцэг, эхийн Монгол дахь дансны хуулга(виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх)
 - ※ **Дансны хуулга авах өдрийн байдлаар 20 сая вон(төвийн бүс), 16 сая вон(төвийн бүс бүс) дүйцэхүйц мөнгийг 30 хоногоос дээш хугацаагаар заавал байршуулсан байх. Материал шалгах үед дансны хуулга нь дээрх хадгаламж нээснээс хуулга авсан өдөр хүртэлх хугацаа 30 хоног хүрэхгүй байх тохиолдолд санхүүгийн чадвар хангахгүйд тооцно(хадгаламжийн журам зөрчсөн болно), (Зэрэглэл доогуур их дээд сургуулиудын хувьд 6 сараас дээш хугацаагаар байршуулна)**
 - Дансны хуулга нь доллар зэрэг воноос бусад валютаар гарсан тохиолдолд, дансны хуулга олгосон тухайн улирлын жишиг огноогоор ханшийг хөрвүүлж бодно. (01.01/ 04.01/ 07.01/ 10.01)
 - БНСУ-ын их дээд сургуулийн бүрэн тэтгэлэгт оюутны хувьд тэтгэлэг болон дансанд байршуулсан мөнгөн дүнгийн нийлбэр 20 сая воноос дээш байна.
 - Жишээ нь) Төвийн бүсийн сургуулийн тэтгэлэгт оюутны хувьд 10 сая вон(элсэлтийн зөвшөөрөл дээрх мөнгөн дүн) + 10 сая вон(дансанд байршуулсан мөнгөн дүн) = 20 сая вон
 - ※ **Эцэг, эх нь нас барсан тохиолдолд төрсөн ах, эгч, дүүгийн дансны хуулга байж болно**
 - **Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт**
 - **Төвийн бүс:**Сөүл хот, Инчон хот, Гёнги муж, Төвийн бүс бүс:Сөүл хот, Инчон хот, Гёнги мужаас бусад бүс
 - Тухайн дансны сүүлийн 3 сарын хуулга(хуулга авах өдрийг хүртэл)
 - Сургалтын зардлыг хариуцах тухай тодорхойлолт, иргэний үнэмлэхийн хуулбар, виз мэдүүлэгчтэй холбоо хамаарлыг нотлох төрөл садангийн лавлагаа
 - Сургалтын зардал хариуцагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт(нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, татварын тодорхойлолт зэрэг)
- Гэрлэлтийн лавлагаа
 - Гэрлэлт бүртгэлгүй ч хүүхэдтэй тохиолдолд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагааг нэмэлтээр өгнө
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхийн лавлагаа)
- Төрсний бүртгэлийн лавлагаа(шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуульд хамаарахгүй)
- Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
- Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)
- Хамгийн сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалтын эх хувь, хуулбарын хамт
 - Одоо сурч байгаа эсвэл сургуулиас гарсан бол: Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, суралцаж буй тодорхойлолт, өмнөх хичээлийн жилийн дүнгийн жагсаалт
 - Апостиль гэрчилгээ авсан сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалт
 - Төгссөн сургуулийн харьяа улсад суугаа БНСУ-ын ЭСЯ-ны консулын баталгаа
 - БНХАУ-д төгсөгчид: БНХАУ-ын Боловсролын яамны харьяа боловсролын түвшин/зэрэг магадлан итгэмжлэх төвөөс олгосон боловсролын зэрэг хамгаалсан эсэх тодорхойлолт.
 - ※ **Солонгос болон Монголд төгсөгчдийн хувьд эх хувиар нь өгөх боломжтой**
- Хэлний чадвар нотлох бичиг баримт(зэрэглэл доогуур сургуульд хамаарна, 2023.07.03-аас хэрэгжинэ)

Ангилал	ТОРИК	Нийгэмд нэгтгэх хөтөлбөр(KIPP)	Сэжон Институт
Коллеж	3-р зэрэг	3-р зэрэгээс дээш болон урьдчилсан дүн 61 онооноос дээш	Дунд шат 1-р түвшин
Аж үйлдвэрийн үндсэн суурь мэргэжил (хөнгөвчилсөн)	2-р зэрэг	2-р зэрэгээс дээш болон урьдчилсан дүн 41 онооноос дээш	Анхан шат 2-р түвшин
Их дээд сургууль	4-р зэрэг	4-р зэрэгээс дээш болон урьдчилсан дүн 81 онооноос дээш	Дунд шат 2-р түвшин

Урлаг спортын мэргэжил (хөнгөвчилсэн)	3-р зэрэг	3-р зэрэгээс дээш болон урьдчилсан дүн 61 онооноос дээш	Дунд шат 1-р түвшин
- Дараах бичиг баримтаас аль нэгийг нь бүрдүүлнэ.			
Ангилал	Бүрдүүлэх бичиг баримт		
ТОРИК	ТОРИК шалгалтын дүнгийн тодорхойлолт		
Сэжон Институт	Сэжон Институтэд суралцан төгссөн сертификат		
Нийгэмд нэгтгэх хөтөлбөр(КИР)	Дараах бичиг баримтаас аль нэгийг нь бүрдүүлнэ. Үүнд: 1) КИР хөтөлбөрийн лавлагаа(Суралцаж буй түвшин нь тодорхой байх) 2) КИР хөтөлбөрийн сертификат*(Байнгын оршин суугч болох хөтөлбөр) 3) КИР хөтөлбөрийн сертификат*(Иргэншил авах хөтөлбөр) 4) КИР хөтөлбөрийн Солонгос хэл болон солонгос соёлын шалгалтад тэнцсэн тодорхойлолт*(KLCT), (Дундын шалгалтад тэнцсэн тодорхойлолт) 5) Байнгын оршин суугч болох шалгалтад тэнцсэн тодорхойлолт(KIPRAT) 6) Иргэншил авах шалгалтад тэнцсэн тодорхойлолт(KINAT) 7) КИР хөтөлбөрийн урьдчилсан шалгалтын дүнгийн тодорхойлолт (Дүн бичигдсэн байна)		
* 2) болон 3) дахь зүйл дээр 5-р зэргээс дээш түвшинд суралцсан талаарх тодорхойлолт, 4) дээр 4-р зэрэгт суралцсан(тэнцсэн) тодорхойлолт, 5) болон 6) дээр 5-р зэргээс дээш түвшинд суралцсан(суралцаагүй гэсэн тэмдэглэгээтэй байсан ч хүлээн зөвшөөрнө) болон тэнцсэн тодорхойлолт - Англи хэл: TOEFL 530 (CBT 197 , iBT 71), IELTS 5.5 , CEFR B2 , TEPS 601 (NEW TEPS 327) - Англи хэлийг албан ёсны хэл болгосон улсын иргэншилтэй эсвэл тухайн улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн оюутны хувьд тухайн улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн талаарх бичиг баримт(төгссөн сургуулийн сертификат зэрэг)-г бүрдүүлж өгсөн тохиолдолд ангил хэлний шаардлага хангасанд тооцно.			

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 сар байна
2. Сургалтын зардал хариуцагчийн хамрах хүрээ
 - Хэлний бэлтгэл/ Их дээд сургуулийн сургалтын зардал хариуцагч: Нэгдүгээр батлан даагч буюу эцэг эхийн тогтмол орлого, санхүүгийн чадварыг татвар төлсөн байдал, нийгмийн даатгалаар нотлох (Батлан даагчийн сарын орлого ойролцоогоор 976,000 вон(2,500,000 төгрөг)-с дээш байх)
 - Эцэг эх нас барсан тохиолдолд хоёр дахь батлан даагч буюу төрсөн ах, эгч, дүү эсвэл авга нагац
3. Дансны хуулга нь виз мэдүүлэх өдрийг хүртэл 1 сараас дээш хугацаагаар байршуулсан байх ба визний мэдүүлгийг шалгаж дуусах хүртэл зарлага хийхгүй байх
 - **1 жилийн нийт сургалтын зардлыг тооцоолох:** Сургалтын төлбөр 1 жил + нэг талын онгоцны билет + амьдралын зардал сар бүр 500 ам.доллар(хоол, байр, хэрэглээний зардал, ном сурах бичиг болон бусад)

2 Солилцооны оюутан (D-2-6)

1) **Олгох хүрээ:** Их дээд сургууль хоорондын хэлэлцээрийн дагуу оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах гэж буй оюутан

2) **Визний төрөл:** 1 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Элсэлтийн зөвшөөрөл болон сургуулийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар
4. Сургууль хооронд байгуулсан хэлэлцээрийн хуулбар, уригч сургуулийн захирлын албан бичиг
5. Харьяа сургуулийн захирлын тодорхойлолт
6. Харьяа сургуулийн оюутны болон дүнгийн тодорхойлолт
7. Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт(шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуульд хамаарахгүй)
 - ✳ **Сургалтын зардал, амьжиргааны зардал болон бусад зардлыг өөрөө хариуцаж байгаа тохиолдолд Элсэлтийн зөвшөөрөл дээр дурдагдсан мөнгийг дансанд 30 хоног байршуулна.**
 - ✳ **Дансны хуулга авах өдрийн байдлаар Элсэлтийн зөвшөөрөл дээр дурдагдсан мөнгийг 30 хоногоос дээш хугацаагаар заавал байршуулах. Материал шалгах үед дансны хуулга нь дээрх хадгаламж нээснээс хуулга авсан өдөр хүртэлх хугацаа 30 хоног хүрэхгүй байх тохиолдолд санхүүгийн чадвар хангахгүйд тооцно.**
8. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн иргэний үнэмлэхийн лавлагаа)
9. Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш, 60-аас доош насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
10. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)
11. Хэлний чадвар нотлох бичиг баримт(зэрэглэл доогуур сургуульд хамаарна)
 - **Солонгос хэл:** Солонгос хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт(TOPIK) **3-р зэрэг**
 - **Англи хэл:** TOEFL **510**

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 сар байна
2. Сургалтын зардал хариуцагчийн хамрах хүрээ
 - Хэлний бэлтгэл/ Их дээд сургуулийн сургалтын зардал хариуцагч: Нэгдүгээр батлан даагч буюу эцэг эхийн тогтмол орлого, санхүүгийн чадварыг татвар төлсөн байдал, нийгмийн даатгалаар нотлох (Батлан даагчийн сарын орлого ойролцоогоор 976,000 вон(2,500,000 төгрөг)-с дээш байх)
 - Эцэг, эх нас барсан тохиолдолд хоёр дахь батлан даагч буюу төрсөн ах, эгч, дүү эсвэл авга нагац

3 Богино хугацаагаар суралцах (D-2-8)

1) Олгох хүрээ: Гадаадын их дээд сургуульд суралцаж буй(жилийн чөлөө авсан оюутан багтана) оюутан хувийн зардлаар 1 жилээс доош хугацаагаар кредит олгох хичээлд суралцах тохиолдолд(GKS тэтгэлэгт оюутан хамаарна)

2) Визний төрөл: 1 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Элсэлтийн зөвшөөрөл болон сургуулийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар
4. Харьяа сургуулийн оюутны болон дүнгийн тодорхойлолт
5. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн иргэний үнэмлэхийн лавлагаа)
6. Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
7. Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
8. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 сар байна
2. Суралцах хугацаа нь 90 хоног хүртэлх бол \$60 хураамжаас чөлөөлж болно
3. Эрдмийн зэрэг олгохгүй богино хугацааны академик сургалт, тусгай лекц зэрэг нь богино хугацаагаар суралцах ангиллын визэд хамаарахгүй



12. ХЭЛНИЙ БЭЛТГЭЛД СУРАЛЦАХ (D-4-1)

1) Олгох хүрээ: Ерөнхий боловсролын сургууль төгсөөд их, дээд сургуулийн харьяа хэлний бэлтгэлд Солонгос хэл суралцах гэж буй иргэн

► **GKS засгийн газрын тэтгэлэгт оюутан:** Визний хураамжаас чөлөөлөгдөнө

► Гадаад оюутан элсүүлэх болон хянах эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн сургуулийн жагсаалтыг **хавсралт 1**-ээс харна уу(www.studyinkorea.go.kr)

2) Визний төрөл: 6 сар хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

3) Товчлол болон тайлбар: Солонгос хэлний бэлтгэл (D-4-1), Гадаад хэлний бэлтгэл (D-4-7)

4) Нэршил тус бүр дээрх виз олгох эсэх хүснэгт:

Төрөл	Визний ангилал	Виз олгох	Кодтой виз олгох	Цахим виз
Шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургууль	D-4-1	О	О	Х
Магадлан итгэмжлэгдсэн сургууль	D-4-1	О	Х	Х
Энгийн их дээд сургууль	D-4-1	Х	О	Х
Зэрэглэл доогуур их, дээд сургууль	D-4-1	Х	О	Х

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Товч намтар(ЭСЯ-ны маягтын дагуу бөглөх, MS Word, Hangul программ ашиглах, заавал өөрийн гараар гарын үсгээ зурах), (GKS тэтгэлэгт оюутан болон БНСУ-ын их дээд сургуулийн бүрэн тэтгэлэгт оюутан, шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд хамаарахгүй)
4. Элсэлтийн зөвшөөрөл болон сургуулийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар
* GKS тэтгэлэгт оюутны хувьд сургалтын албаны даргын урилгыг хавсаргана
5. Хэлний бэлтгэлийн төлөвлөгөө(хичээлийн хуваарь, хичээл заах багш нарын хүснэгт), хэлний бэлтгэл хичээлийн өнөөгийн байдал(сургуулийн өөрийн маягт)
6. Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт болон дансны хуулга
 Дансны хуулга(*Дансны хуулга дээр хуулга авсан он, сар, өдрийг тодорхой тэмдэглэгдсэн байх)
- Өөрийн, эсвэл эцэг, эхийн Монгол дахь дансны хуулга(виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх)
* **Дансны хуулга авах өдрийн байдлаар 10 сая вон(төвийн бүс), 8 сая вон(төвийн бус бүс) дүйцэхүйц мөнгийг 30 хоногоос дээш хугацаагаар заавал байршуулсан байх. Материал шалгах үед дансны хуулга нь дээрх хадгаламж нээснээс хуулга авсан өдөр хүртэлх хугацаа 30 хоног хүрэхгүй байх тохиолдолд санхүүгийн чадвар хангахгүйд тооцно(хадгаламжийн журам зөрчсөн болно)**
 БНСУ-ын их дээд сургуулийн бүрэн тэтгэлэгт оюутны хувьд тэтгэлэг болон дансанд байршуулсан мөнгөн дүнгийн нийлбэр 10 сая воноос дээш байна.
Жишээ) Төвийн бүсийн сургуулийн тэтгэлэгт оюутны хувьд 5 сая вон(элсэлтийн зөвшөөрөл дээрх мөнгөн дүн) + 5 сая вон(дансанд байршуулсан мөнгөн дүн) = 10 сая вон
* **Эцэг, эх нь нас барсан тохиолдолд төрсөн ах, эгч, дүүгийн дансны хуулга байж болно**
 Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
- Тухайн дансны сүүлийн 3 сарын хуулга(хуулга авах өдрийг хүртэл)
- Сургалтын зардлыг хариуцах тухай тодорхойлолт, иргэний үнэмлэхийн хуулбар, виз мэдүүлэгчтэй холбоо хамаарлыг нотлох төрөл садангийн лавлагаа
- Сургалтын зардал хариуцагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт(нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, татварын тодорхойлолт зэрэг)
7. Гэрлэлтийн лавлагаа
- Гэрлэлт бүртгэлгүй ч хүүхэдтэй тохиолдолд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагааг нэмэлтээр өгнө
- Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн иргэний үнэмлэхийн лавлагаа)
8. Төрсний бүртгэлийн лавлагаа (шилдэг магадлан итгэмжлэгдсэн сургуульд хамаарахгүй)
9. Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш, 60-аас доош насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна.)
10. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалтын эх хувь, хуулбарын хамт
 - a) Апостиль гэрчилгээ авсан сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалт
 - b) Төгссөн сургуулийн харьяа улсад суугаа БНСУ-ын ЭСЯ-ны консулын баталгаа
 - c) БНХАУ-д төгсөгчид: БНХАУ-ын Боловсролын яамны харьяа боловсролын түвшин/зэрэг магадлан итгэмжлэх төвөөс олгосон боловсролын зэрэг хамгаалсан эсэх тодорхойлолт.*** Солонгос болон Монголд төгсөгчдийн хувьд эх хувиар нь өгөх боломжтой**
11. Сүрьеэгийн шинжилгээний бичиг (**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)

АНХААРАХ ЗҮЙЛС

1. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 сар байна
2. Сургалтын зардал хариуцагчийн хамрах хүрээ
- Хэлний бэлтгэл/ Их дээд сургуулийн сургалтын зардал хариуцагч: Нэгдүгээр батлан даагч буюу эцэг эхийн тогтмол орлого, санхүүгийн чадварыг татвар төлсөн байдал, нийгмийн даатгалаар нотлох. (Батлан даагчийн сарын орлого ойролцоогоор 976,000 вон(2,500,000 төгрөг)-с дээш байх)
- Эцэг эх нас барсан тохиолдолд хоёр дахь батлан даагч буюу төрсөн ах, эгч, дүү эсвэл авга нагац
3. Дансны хуулга нь виз мэдүүлэх өдрийг хүртэл 1 сараас дээш хугацаагаар байршуулсан байх ба визний мэдүүлгийг шалгаж дуусах хүртэл зарлага хийхгүй байх
- **6 сарын нийт сургалтын зардлыг тооцоолох:** Сургалтын төлбөр 6 сар + нэг талын онгоцны билет + амьдралын зардал сар бүр 500 ам.доллар(хоол, байр, хэрэглээний зардал, ном сурах бичиг болон бусад)



13. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАХ (D-4-3)

1) Олгох хүрээ: Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны урилгаар бүрэн тэтгэлэг авч суралцах гэж буй сурагч

2) Визний төрөл: 1 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ(**хүчинтэй хугацаа 3 сар**)
4. Уригч байгууллагын албан бичиг
5. Уригч байгууллагын аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар
6. Тэтгэлгийн гэрчилгээ
7. Харьяа сургуулийн сурагчийн тодорхойлолт, дүнгийн тодорхойлолт
8. Төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхийн лавлагаа)
9. Цагдаагийн газрын тодорхойлолт(18–аас дээш насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
10. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалтын эх хувь, хуулбарын хамт
11. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)



14. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ (D-8-1)

1) Олгох хүрээ: БНСУ-ын “Гадаад иргэний хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль”-н дагуу гадаад иргэдийн хөрөнгө оруулалттай БНСУ-ын хуулийн этгээдийн удирдлага, үйл ажиллагаа мөн үйлдвэрлэл, технологи, судалгааны салбарт ажиллах **мэргэжлийн боловсон хүчин**

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Томилогдон суух тохиолдолд томилолтын тушаал, ажлын газрын тодорхойлолт
4. Гадаад иргэний хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээдийн тодорхойлолт хуулбар
5. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, үл хөдлөхийн тодорхойлолт, хувьцаа эзэмшигч өөрчлөлтийн лавлагааны эх хувь
6. БНСУ-ын “Гадаад иргэний хөрөнгө оруулалтыг дэмжих” тухай хуулийн хэрэгжүүлэх журмын дагуу “Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яам”-ны сайдын тогтоосон “бүс нутгийн төв байгууллага(9-р бүлгийн 4-р заалт) болон судалгаа, хөгжлийн төв(16-р зүйл)” нь ажиллах хүчний нэрсийн жагсаалтыг(овог нэр, албан тушаал, боловсролын түвшин, судалгааны туршлага, ажиллах салбар гэх мэт) нэмэлтээр бүрдүүлнэ.
- 7. Хөрөнгө оруулалтыг нотлох бичиг баримт**
 - 1) Бэлэн мөнгө
 - Тухайн улсын гааль эсвэл тус улсын банк(санхүүгийн байгууллага)-ны валют гаргах зөвшөөрөл (холбогдох хүн)
 - Хөрөнгө оруулсан лавлагаа(шилжүүлгийн баримт, гадаад валют худалдан авалтын баримт, гаалийн мэдүүлгийн хуудас гэх мэт)
 - 2) Бэлэн материал
 - Бэлэн материал оруулсан тухай тодорхойлолт(гаалийн ерөнхий газрын даргын олгосон)
 - Гаалийн орлогын мэдүүлгийн баримтын хуулбар
- 8. 300 сая вон хүртэлх дүнгээр хөрөнгө оруулсан тохиолдолд бүрдүүлэх нэмэлт бичиг баримт**
 - Хөрөнгө ашигласан тухай баримт(бараа худалдан авсан баримт, оффисын засал чимэглэлийн зардал, дотоодын банкны дансны хуулга)
 - Аж ахуй нэгжийн оршин байгааг нотлох баримт(оффисын түрээсийн гэрээ, оффисын анх байсан төрх, ажиллах орчин, самбарын зураг гэх мэт материал)
9. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)
10. Цагдаагийн газрын тодорхойлолт
11. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
12. Төрсний бүртгэлийн лавлагаа(өөрийн болон үр хүүхэд)



15. ГАДААД ХУДАЛДАА (D-9-4)

- 1) **Олгох хүрээ:** БНСУ-ын “Гадаад иргэний хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль”-н дагуу хөрөнгө оруулалтын бүртгэл хийж хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн лавлагаа авсан 300 сая воноос илүү хөрөнгөтэй хувийн бизнес эрхлэгч

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
 3. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хуулбар(холбогдох хүн), хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээдийн гэрчилгээ(холбогдох хүн)
 4. Хамтын үйл ажиллагааны гэрээ эх хувь, хуулбар(холбогдох хүн)
 - Нийт хөрөнгө, эзэмшиж буй хувь болон ашиг хуваарилах арга зэргийг багтаасан байх
 5. **Бизнесийн хөрөнгө оруулсныг нотлох бичиг баримт**
 - Шилжүүлгийн баримт, гадаад валют худалдан авалтын баримт, гаалийн мэдүүлгийн хуудас, тус улсын гаалиар гаргах зөвшөөрөл зэрэг
 6. **Хөрөнгө ашиглалтыг нотлох бичиг баримт**
 - Бараа худалдан авсан баримт, оффисын засал чимэглэлийн зардал, дотоодын банкны дансны хуулга
 7. Үйл ажиллагаа явуулж буйг нотлох бичиг баримт
 - Экспорт/импортын зөвшөөрөл, НӨАТ-н мэдүүлгийн бичиг
 8. БНСУ-н иргэнийг ажилд авах амлалт бичиг(**холбогдох хүн**), (ЭСЯ-ны цахим хуудаснаас харна уу)
 9. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)
 10. Цагдаагийн газрын тодорхойлолт
 11. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
 12. Төрсний бүртгэлийн лавлагаа(өөрийн болон үр хүүхэд)
 13. Аж ахуй нэгжийн оршин байгааг нотлох баримт
 - Оффисын түрээсийн гэрээ, оффисын анх байсан төрх, ажиллах орчин, самбарын зураг гэх мэт материал
- ※ **Зөвхөн тухайн визийг мэдүүлэхийн өмнө (С-3-4) богино хугацааны визээр үйл ажиллагаа явуулсан тохиолдолд доорх бичиг баримтыг нэмэлтээр бүрдүүлнэ**



16. АЖЛЫН БАЙР ХАЙХ (D-10)

1) Олгох хүрээ: Их дээд сургуулийн багш (E-1), Ярианы ментор (E-2), Судалгаа (E-3), Технологийн зааварлагч (E-4), Мэргэжлийн ажил эрхлэлт (E-5), Урлагийн тоглолт (E-6), Тусгай үйл ажиллагаа (E-7) зэрэг ангилалд хамаарах салбарт ажилд орох зорилгоор сургалтад суух, ажлын байр хайх гэж буй иргэн

2) Визний төрөл: 6 сар хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг, хураамж \$60
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Ажил байдлын тодорхойлолт* эсвэл боловсролын гэрчилгээ**
4. Дүнгийн тодорхойлолт(БНСУ-д коллеж болон их дээд сургууль төгсөгчдөд хамаарна)
5. Судалгааны байгууллагын тодорхойлолт*** (судалгааны байгууллагад судалгаа хийж дуусгасан хүнд хамаарна)
6. Хүчин төгөлдөр Солонгос хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын(TOPIK) **4-р зэрэг**(хамрагдсан хүнд хамаарна), Korea immigration and intergration program (хамрагдсан хүнд хамаарна)
7. Ажлын байр хайх төлөвлөгөө
8. Ажлын байр хайх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
- Өөрийн, эсвэл эцэг, эхийн монгол дахь дансны хуулга(виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх)
- * Дансны хуулга авах өдрийн байдлаар \$4,500 ам.доллартой дүйцэхүйц мөнгийг 30 хоногоос дээш хугацаагаар заавал байршуулах. Материал шалгах үед дансны хуулга нь дээрх хадгаламж нээснээс хуулга авсан өдөр хүртэлх хугацаа 30 хоног хүрэхгүй байх тохиолдолд санхүүгийн чадвар хангахгүйд тооцно(хадгаламжийн журам зөрчсөн болно)**
9. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
10. Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш, 60-аас доош насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
11. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)

АНХААРАХ ЗҮЙЛС

- * Дэлхийн шилдэг 500 байгууллагад ажиллаж байсан туршлагатай бол зөвхөн ажил байдлын тодорхойлолт (ажлын газрын тодорхойлолт) өгнө. Боловсролын гэрчилгээ шаардлагагүй.
- ** Дэлхийн шилдэг 200 их дээд сургууль төгссөн бол төгсөлтийн диплом, төгсөх гэж буй тодорхойлолт, дипломын тодорхойлолт зэргээс аль нэгийг нь өгөх боломжтой. Дүнгийн тодорхойлолт шаардлагагүй.
- *** БНСУ-д судалгааны байгууллагын тодорхойлолт дээр тухайн судалгааны байгууллагын даргын олгосон тодорхойлолт байх ба тодорхойлолт дээр судалгааны нэр, судалгааны хугацаа, судалгааг дуусгасан эсэх зэргийг зайлшгүй тэмдэглэсэн байна.



17. ОРШИН СУУХ (F-1)

1) Олгох хүрээ:

- **F-1-3:** Дипломат (A-1), албан ажил (A-2) болон хэлэлцээрийн (A-3) ангиллын визээр оршин суугч түүний шууд бус хамаарал бүхий гэр бүл
- **F-1-9:** Хилийн чанадад дахь Солонгос гаралтай иргэн (F-4) ангиллын визтэй иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхэд
- **F-1-13:** Гадаад иргэншилтэй сурагчийн(ерөнхий боловсролын сургууль) эцэг эх болон өвөө эмээ, ах эгч зэрэг гэр бүл
- **F-1-21:** БНСУ дахь дипломат байгууллагын ажилтны гэрийн үйлчлэгч(дипломат ажилтантай адил иргэншилтэй байх)
- **F-1-22~24:** Хөрөнгө оруулагч болон мэргэжлийн боловсон хүчний гадаад гэрийн үйлчлэгч

2) Визний төрөл: 1 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

НИЙТЛЭГ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Цагдаагийн газрын тодорхойлолт(18-аас дээш, 60-аас доош насны анх удаа виз мэдүүлж буй иргэнд хамаарна)
4. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа(эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
5. Сүрьеэгийн шинжилгээний бичиг(**ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2**)

1

Дипломат (A-1), албан ажил (A-2) болон хэлэлцээрийн (A-3) ангиллын визээр оршин суугч түүний шууд бус хамаарал бүхий гэр бүл (F-1-3)

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 1-5. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх нийтлэг бичиг баримт
6. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт
7. Хамт амьдрах эсвэл урт хугацаагаар оршин суух шалтгааныг нотлох бичиг баримт

2

Хилийн чанадад дахь Солонгос гаралтай иргэн (F-4) ангиллын визтэй иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхэд

※ Бүртгэлтэй хаягийн харьяа ЭСЯ-нд мэдүүлнэ

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 1-5. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх нийтлэг бичиг баримт
6. Хилийн чанадад дахь Солонгос гаралтай иргэн (F-4) ангиллын визтэй иргэний хаягийн бүртгэл хийлгэсэн бичиг баримт эсвэл визтэй хэсгийн хуулбар
7. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт(гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа зэрэг)
8. Оршин суух газар болон амьжиргааны чадварыг нотлох бичиг баримт
 - Оршин суух газрын нотлох бичиг баримт(түрээсийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар гэх мэт)
 - Орлого нотлох бичиг баримт(ажлын газрын тодорхойлолт, цалингийн данс эсвэл харилцах дансны гүйлгээний хуулга гэх мэт)

3**Гадаад иргэншилтэй сурагчийн(ерөнхий боловсролын сургууль) эцэг эх болон өвөө эмээ, ах эгч зэрэг гэр бүл (F-1-13)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

- 1-5. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх нийтлэг бичиг баримт
6. Гадаад иргэншилтэй сурагчийн(ерөнхий боловсролын сургууль) элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ болон сургуулийн сурагчийн тодорхойлолт
7. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт
8. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт(тогтсон хэмжээнээс дээш мөнгөн дүнг 1 сараас дээш хугацаанд хадгалсныг нотлох банкны тодорхойлолт зэрэг бичиг баримт)
 - Дотоодын төрийн байгууллага эсвэл банкнаас олгосон(баталгаа эсвэл нотариат), орлогын мэдүүлгийн тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгө эзэмшигчийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгө худалдаалах гэрээ, хадгаламжийн дансны тодорхойлолт гэх мэт
 - **Жилийн орлого 37,400,000 воноос дээш байх эсвэл 199 сая вонтой тэнцэхүйц хөрөнгө эзэмшигч**

4**БНСУ дахь дипломат байгууллагын ажилтны гэрийн үйлчлэгч(дипломат ажилтантай адил иргэншилтэй байх) (F-1-21)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

- 1-5. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх нийтлэг бичиг баримт
6. Дипломат байгууллагын албан бичиг
7. Хөдөлмөрийн гэрээ
8. Ажил олгогчийн биеийн байцаалтын хуулбар

5**Хөрөнгө оруулагч болон мэргэжлийн боловсон хүчний гадаад гэрийн үйлчлэгч (F-1-22~24)****БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ**

- 1-5. Виз мэдүүлэгчийн бүрдүүлэх нийтлэг бичиг баримт
6. Гадаад хөрөнгө оруулалтын мэдүүлгийн хуудас(аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар) эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
7. Ажил олгогчийн ажлын тодорхойлолт(биеийн байцаалтын лавлагаа)
8. Ажил олгогчийн орлогыг нотлох бичиг баримт
 - Орлогын албан татвар төлсөн баримт, орлогын мэдүүлгийн тодорхойлолт, цалингийн задаргаа, дансны хуулга гэх мэт
9. Дотоодын ажилтан ажиллуулж буйг нотлох баримт(хөрөнгө оруулалтын дүн \$500,000 ам.доллороос бага тохиолдолд)
 - Орлогын албан татвар төлсөн баримт, орлогын мэдүүлгийн тодорхойлолт, цалингийн задаргаа, дансны хуулга гэх мэт
10. Гэрийн үйлчлэгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ
11. Батлан даалтын бичиг
12. Гэрийн үйлчлэгчийн боловсролыг нотлох бичиг баримт(сургууль төгссөн гэрчилгээ гэх мэт)
13. Ажил олгогчийн гэрийн үйлчлэгчээр 1 жилээс дээш ажилласныг нотлох баримт
 - Хөдөлмөрийн гэрээ, цалингийн хуудас, дансны хуулга гэх мэт



18. ГЭРЛЭЛТ ЦАГААЧЛАГЧИЙН ЭЦЭГ ЭХ, ГЭР БҮЛ (F-1-5)

1) Олгох хүрээ:

НӨХЦӨЛ	<p>- Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх дэмжлэг(жирэмсэн эсвэл асрах) Гэрлэлт цагаачлагч, Солонгос эхнэр/нөхөр нь жирэмсэн болон асаргаа шаардлагатай бага насны хүүхэд өсгөн хүмүүжүүлж байгаа тохиолдолд БНСУ-д зорчих виз мэдүүлсэн өдрөөс тооцож, хүүхэд 9 нас хүрэх оны 9-р сарын сүүл хүртэл урих боломжтой. (1 хүүхэд тус бүр дээр 1 хүн урих боломжтой, эцэг эх хамт эсвэл дараалуулан нийт 2 удаа урьж болно)</p> <p>- Өрх толгойлсон эцэг, эх эсвэл олон хүүхэдтэй гэр бүл (3 ба түүнээс дээш насанд хүрээгүй хүүхэд) Виз мэдүүлсэн өдрөөс тооцож, хүүхэд 12 нас хүрэх оны 9-р сарын сүүл хүртэл урих боломжтой. (1 хүүхэд тус бүр дээр 1 хүн урих боломжтой(эцэг эхээ хамтад нь дараалуулан урьж болно), урих тоо хязгааргүй)</p>
УРИГДАГЧ	<p>1) Гэрлэлт цагаачлагчийн эцэг, эх 2) Гэрлэлт цагаачлагчийн эцэг, эх нь хоёулаа нас барсан эсвэл өвчтэй, өндөр настай зэрэг зайлшгүй шалтгаанаар БНСУ-д зорчих боломжгүй тохиолдолд тус улсын "Иргэний хууль"-д зааснаар насанд хүрсэн төрсөн ах, эгч, дүү болон өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхэд. * Зөвхөн төрсөн ах, эгч, дүү болон өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхэд нь өөрөө насанд хүрээгүй хүүхэдгүй тохиолдолд урих боломжтой.</p>

"Хүүхэд асран халамжлахад туслах" нөхцөлд хамаарах хүүхэд

БНСУ-ын иргэншил авсан эсвэл иргэншлийн хуульд заасан иргэншил хүсэх/бүртгүүлэхэд хүсэлтээ өгөөд журам хэрэгжих шатандаа явж буй хүүхэд бол доорх 3 нөхцөлийн аль нэгийг хангасан байна.

- 1) Гэрлэлт цагаачлагч болон Солонгос улсын иргэний дундаас төрсөн хүүхэд
- 2) (Нэмэлт) Гэрлэлт цагаачлагчийн солонгос иргэнтэй гэрлэхээс өмнө төрсөн хүүхэд хэдий ч солонгос эхнэр/нөхөртөө өргүүлсэн бол
- 3) "БНСУ-ын иргэншил авсан гэрлэлт цагаачлагч"-ийн төрсөн хүүхэд

Хүүхэд сургуульд сургах үүргийг биелүүлээгүй тохиолдолд урих эрх хязгаарлагдана

- Сургуулийн насны хүүхэдтэй боловч, уригч тал хүүхдээ сургуульд сургах үүргээ биелүүлээгүй бол Монгол дахь гэр бүлээ урих боломжгүй.
- Зөвхөн, өвчин зэрэг зайлшгүй шалтгааны улмаас хүүхэд бага сургуульд орох эсвэл анги дэвших нь хойшлогдсон тохиолдолд, урих **нас нь хэтэрсэн ч бага сургуулийн 3-р ангийн 9 дүгээр сарын сүүл (энгийн нөхцөл) эсвэл 6-р ангийн 9 дүгээр сарын сүүл(өрх толгойлсон эцэг эх, олон хүүхэдтэй гэр бүл) хүртэлх хугацаанд урих боломжтой.**

2) Визний төрөл(хүчинтэй хугацаа/оршин суух хугацаа): Богино хугацааны виз (S): 3 сар/90 хоног

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Хөдөлмөр эрхлэхгүй тухай амлалт бичиг
4. Гэрлэлт цагаачлагчийн гэр бүлийн холбоо хамаарлын лавлагаа
 - **Эцэг, эх**
- Төрсний бүртгэлийн лавлагаа, үрчилэлтийн гэрчилгээ(үрчилсэн эцэг, эх), гэрлэлт бүртгэлийн лавлагаа, лавлагаа тус бүрийг E-Mongolia-аас авсан байх, гэр бүлийн зураг
 - **Төрсөн ах, эгч, дүү**
- Гэрлэлт цагаачлагчийн төрсний бүртгэлийн лавлагаа, уригдагчийн төрсний бүртгэлийн лавлагаа, гэрлэлт бүртгэлийн лавлагаа, лавлагаа тус бүрийг E-Mongolia-аас авсан байх, гэр бүлийн зураг
 - **Өмнөх гэрлэлтээс төрсөн хүүхэд**
- Төрсний бүртгэлийн лавлагаа, лавлагаа тус бүрийг E-Mongolia-аас авсан байх, гэр бүлийн зураг
* Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох шаардлагатай тохиолдолд ДНХ-н шинжилгээний хариуг нэмэлтээр шаардана.
5. Эцэг эх нь БНСУ-д зорчих боломжгүй шалтгаан болон нотлох бичиг баримт(**холбогдох хүн**)
 - 60 ба түүнээс дээш өндөр настай шалтгааны улмаас нэвтрэх боломжгүй тохиолдолд түүнийг нотлох бичиг баримт
 - Өвчтэй эсвэл нас барсан эсэхийг гэрчлэх бичиг баримт(**ЭСЯ-аас заасан эмнэлгийн тодорхойлолт**)
 - * **ЭСЯ-наас заасан Монгол эмнэлэг:** Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв,

Улсын 1, 2, 3-р төв эмнэлэг, Интермед эмнэлэг, Грандмед эмнэлэг, УБ Сонгдо эмнэлэг
6. Сүрьеэгийн оношилгооны хуудас(ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2)
* "Хилийн хоригийн асуудлыг зохицуулах журам"-ын дагуу хилийн хоригийн хугацааг даган хэрэгжүүлж виз олголтыг хязгаарлана. Зөвхөн, өмнө нь хууль бусаар хөдөлмөр эрхэлж байсан иргэний хувьд хэрэг дуусгавар болсон өдрөөс эхлээд 5 жилийн туршид виз олголтыг хязгаарлана.

УРИГЧ ТАЛ БҮРДҮҮЛЭХ

1. Иргэний үнэмлэхийн хуулбар
 2. Урилга(эх хувь)
 - Батлан даалтын бичиг(батлан даах хугацаа: БНСУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлээд 3 жил)
 - Хууль бусаар оршин суух/ажил хийхгүй байх амлалт бичиг
 3. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт(сүүлийн 3 сарын дотор авсан байх)
